

2022



ЖИЛИЙН
ТАЙЛАН

Бүлэг

1

**КОМПАНИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

Компанийн тухай
Үйл ажиллагааны голлох үзүүлэлтүүд
Үйл ажиллагааны онцлог
Түүхэн амжилтууд
Тайлант үеийн онцлох үйл явдал

Бүлэг

2

**СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ
БА ГҮЙЦЭТГЭЛ**

Стратегийн чиглэл
Зах зээлд давамгайлах
Босоо интеграц
Бүтээгдэхүүн , үйлчилгээний ялгарал
Үнэнч хэрэглэгчийг нэмэгдүүлэх
Технологийн дэвшил ашиглан борлуулалтын сувгийг
нэмэгдүүлэх

Бүлэг

3

**КОМПАНИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Олон улсын конвiniенс дэлгүүрийн зах
зээлийн чиг хандлага
Монгол улсын конвiniенс дэлгүүрийн
зах зээл
Гүйцэтгэх удирдлагын тайлан

Бүлэг

4

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгаль орчин
Нийгэм
Засаглал

ИРЭЭДҮЙГ ЧИГЛЭСЭН МЭДЭГДЛИЙН ТАЛААРХ АНХААРУУЛГА

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн энэхүү тайланд “ирээдүйг чиглэсэн” зарим мэдэгдэл агуулагдсан болно. Тухайлбал, тус тайланд “бид таамаглаж байна, бид тооцоолж байна, бид зорьж байна, бид төлөвлөж байна” гэх мэт үгстэй ойролцоо үг, мөн ирээдүй цагийг илэрхийлэх үгс ашиглагдсан болно.

Ирээдүйг чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлын баталгаа биш бөгөөд бидний таамагласан нөхцөл байдал биелэхгүй байх магадлалтай ба тэдгээр таамаглалуудад хэт найдах нь учир дутагдалтайг анхаарна уу.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлага нь тус тайлангийн “Гүйцэтгэх удирдлагын тайлан” бүлэгт тайлбарлагдсан эрсдэл, тодорхойгүй байдал гэх мэт хүчин зүйлс, мөн үүгээр хязгаарлагдахгүй зүйлсээс хамаарч материаллаг зөрүүтэй байж болно. Тиймээс, эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлыг харгалзан үзэж ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг шууд утгаар нь бодитоор биелнэ хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Мөн, компанийн зүгээс шинэ мэдээ мэдээлэл болон ирээдүйд гарах ялгаатай үр дүн эсвэл аливаа бусад шаардлагын улмаас энэхүү тайланд тусгагдсан ирээдүйд чиглэсэн таамаглалуудыг шинэчлэх эсвэл засварлах аливаа үүрэггүй болохыг мэдэгдэж байна.

ТУЗ-ын даргын МЭНДЧИЛГЭЭ


Хөрөнгө оруулагч таны энэ өдрийн амгаланг айлтгая.



Бидний хамтдаа өсөж хөгжих урт аяллын хэд хэдэн чухал амжилт болон цаашдын төлөвлөгөөний талаарх өөрийн бодлыг та бүхэнтэй хуваалцаж буйдаа таатай байна.

Улс орны хөгжлийн бодит шалгуур нь аливаа дэвшилтэт үнэ цэнийг тухайн улс дах олон хүнд хүргэх билээ. Үүнийг стандартаар дамжуулан хүргэх бөгөөд стандарт гэдгийг хамгийн олон оролцогч талд хамгийн их үнэ цэнийг хүргэж чадахуйц олон улсад туршигдаж шалгарсан, оновчтой загвар гэж ойлгож болно. Ийм ч учраас бид хөгжсөн улсын иргэд нь өдөр тутам ашигладаг үйлчилгээний цогц стандартыг нэвтрүүлж Монголчуудын амьдралын стандартыг дээшлүүлэхийг зорьсон.

Конвениенс дэлгүүрийн стандарт нь АНУ-д 1950 онд, Японд 1970 онд, Солонгост 1990 онд нэвтэрч, өдгөө эдгээр өндөр хөгжилтэй орнуудын иргэдийн өдөр тутмын амьдралыг тэтгэгч, нийгмийн амин чухал дэд бүтэц болтлоо хөгжсөн байна. Манай Компанийн 5 жилийн бүтээн байгуулалтын үр нөлөө нь Монголчуудын өдөр тутмын амьдралын ая тух, бүтээмжид эерэг нөлөөлсөн гэж итгэж байгаа бөгөөд цаашид улам их үнэ цэнийг тасралтгүй бүтээж, өндөр хөгжилтэй орны иргэдийн түвшинд хүргэхээр хичээнгүйлэн ажилласаар байна.



Бид конвинеенс үйлчилгээний тулгуур болох ложистик, хоол үйлдвэрлэл, мэдээллийн систем, хүн бүрд ойр байрлах дэлгүүр зэрэг дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхийн зэрэгцээ эдгээр дэд бүтцээр дамжуулан үйлчлүүлэгчдэдээ чанартай үйлчилгээг өдөр тутам хүргэх мэргэжилтнүүдийг бэлтгэх шаардлагатай. Ингэснээр Монголчуудын ая тухтай амьдралын стандарт дээшлэх, ур чадвартай мэргэжилтнүүдийн тоо нэмэгдэх, хүнсний аюулгүй байдлыг хангасан нийлүүлэлтийн сүлжээ үүсэх, жижиг дунд бизнес эрхлэгчид бидний цогцлоосон дэд бүтцийг ашиглан бизнесээ өргөжүүлэх, цаашлаад Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудад бодитой хувь нэмэр оруулах чадвартай компаниуд олноор бий болох боломжтой.

Бид бизнесийн дэд бүтцээ байгуулж, мэргэжилтнүүдээ бэлтгэхэд өнгөрсөн 5 жилийн хугацаанд 140 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг хийжээ. Нийгэмд том өөрчлөлтийг авч ирж, хүн бүрийн ая тухтай амьдралын стандартыг дээшлүүлэхэд бидэнтэй зорилго нэгдэн, итгэл хүлээлгэж, биднийг тасралтгүй дэмжсээр ирсэн хөрөнгө оруулагч танд баярлалаа.

Монгол Улсынхаа хөгжлийг түүчээлж, зуун дамжсан үнэ цэн бүтээх компанийг хамтдаа цогцлооё.



А.ГАНХУЯГ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Гүйцэтгэх захирлын МЭНДЧИЛГЭЭ

Хөрөнгө оруулагч таны энэ өдрийн амгаланг айлтгая.



2022 он бидний хувьд цар тахлын дараах сэргэлтийн боломжийг ашигласан, Компанийн хэтийн үнэ цэнийг өсгөх стратегийн тулгуур дэд бүтцүүдийг дэлхийн жишигт хүргэсэн жил байлаа.

Бид 2022 онд 120 салбар дэлгүүрийг шинээр байгуулж, 2023 оны 3-р сард нийт 300 салбар дэлгүүртэй болсон бөгөөд өнөөдөр өдөр бүр 110 гаруй мянган хүнд үйлчилж байна. Мөн бид зах зээлээ тэлж, Дархан-Уул аймгийн

Дархан хот, Төв аймгийн Баянчандмань суманд салбар дэлгүүрээ нээгээд байгаа бөгөөд 2023 оны 4-р сард Орхон аймгийн Эрдэнэт хотод салбар дэлгүүрээ нээхээр ажиллаж байна.

Өдөр бүр CU дэлгүүрээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн тоо хурдтай өсөж байгаа нь бидэнд зах зээлийн илүү том боломж байгааг батлан харуулж буй бөгөөд дунд хугацаанд бид 1000 дэлгүүртэй болох зорилго тавин ажиллаж байна.

Бид 2022 онд цар тахлын дараах нийлүүлэлтийн хомсдол, өртгийн өсөлт, ОХУ ба Украйны дайнаас үүдсэн тээвэр логистикийн хүндрэл, хүний нөөцийн хомсдол, валютын хомсдол болон төгрөгийн ханш сулралт зэрэг олон сорилт бэрхшээлүүдтэй тулгарсан хэдий ч хүйтэн хэлхээний түгээлтийн төвийн өргөтгөл, түгээлтийн төвүүдийн хагас автоматжуулалт, худалдааны удирдлагын үндсэн системийн шинэчлэл, хоолны үйлдвэрийн хүчин чадлын өргөтгөл болон хүнсний аюулгүй байдлын олон улсын HAC-CP стандартын баталгаажилт зэрэг чухал ажлуудыг хийж гүйцэтгэн, дэд бүтцүүдээ олон улсын стандартын шаардлагад нийцүүлж чадлаа. Ингэснээр бид ирэх жилүүдэд дэлгүүрийн тоогоо хурдтай нэмэхтэй зэрэгцээд үйлчилгээний чанараа дэлхийн жишигт хүргэх нөхцөлийг бүрдүүлээ.

Бид дэлгүүрийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг тэтгэх дэд бүтцүүдээ олон улсын жишигт хүргэсэн тул 2023 оны 3-р сард Франчайзийн хөтөлбөрөө зарлан, жижиг дунд бизнес эрхлэгчдэд өөрийн байгуулсан салбар дэлгүүрүүдийг урт хугацааны франчайзийн гэрээгээр эзэмшүүлж эхэллээ. Ингэснээр бидний үйлчилгээний чанар, стандарт сайжирч, Компанийн ашигт ажиллагаанд эерэг нөлөө авч ирнэ.

Манай Компанийн үнэт зүйлсийн нэг нь бидний нийгэмд өгч буй үнэ цэн юм. Бид 2022 онд байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогоо баримтлан НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилтын 9 зорилтод өөрсдийн бодитой хувь нэмрийг орууланажиллалаа. Ингэснээр бид үйлчлүүлэгч, хамт олон, нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч, төр засаг ба олон нийттэй үнэт зүйлсээрээ нэгдэж, компанид итгэх итгэлийг нэмэгдүүлэн, Компанийн нийт эрсдэлийг бууруулж буй юм.

2022 онд бид 285 салбар дэлгүүрээрээ нэг сард дунджаар 3 гаруй сая хүнд үйлчилж, нийт 261 тэрбум төгрөгийн борлуулалтыг гүйцэтгээд байна. Компанийн бодит үнэ цэнийг илтгэгч олон үзүүлэлт байдгийн дотор жижиглэнгийн худалдааны компанийн үнэлгээнд түлхүү хэрэглэгддэг нь Price-to-Sales (P/S) буюу компанийн нийт үнэлгээ нь борлуулалтын хэдэн хувьтай дүйцэж байгааг тооцдог харьцаа үзүүлэлт юм. Конвиниенс дэлгүүрийн сүлжээ хөгжсөн орнуудад бидэнтэй ижил төстэй эрхэлдэг компаниудын Price-to-sales харьцаа дунджаар 0.7 ба 1.2-ийн хооронд хэлбэлзэж байна. Бид салбар дэлгүүрийн тоогоо нэмэхийн хэрээр CU брэндээр үйлчлүүлдэг үйлчлүүлэгчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж, борлуулалт хурдтай өсөж буй тул Компанийн үнэлгээ ч цаашдаа урт хугацаанд тогтмол өснө гэдэгт бид бүрэн итгэлтэй байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн хамт олон бид "Дэлхийн стандартаар хүмүүсийн өдөр тутмын амьдралыг хялбаршуулах" зорилгын дор нэгдэн эрхэм хувьцаа эзэмшигч та бүхний итгэлийг даан, Компанийн үнэ цэнийг өсгөх ажлуудыг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллах болно.

CU-д ТАВТАЙ МОРИЛНО УУ!



Г.ЧИНЗОРИГ

Гүйцэтгэх захирал



Nice to

CU

100% Salads



КОМПАНИЙН ТУХАЙ

Өдгөө Улаанбаатар хотын иргэдийн амьдралын салшгүй хэсэг болж өргөжин тэлж буй Сэнтрал Экспресс (CU) төслийг 2015 онд Премиум Групп ХХК эхлүүлж, Монгол Улсад конвiniенс сүлжээ дэлгүүрийн анхны шавыг тавьсан. Улмаар 2017 онд Сэнтрал Экспресс - Си Ви Эс ХХК-ийг үүсгэн байгуулснаар хэрэглэгч ая тухтай орчинд, өөрийн бүхий л хэрэгцээг нэг дороос хангах боломжтой сүлжээ дэлгүүрийн бизнес загварыг Монгол Улсад анх удаа нэвтрүүлсэн юм.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (MSE: CUMN) нь Монгол Улсын жижиглэн худалдаа болон конвiniенс дэлгүүрийн зах зээлд тэргүүлэгч компани бөгөөд 2018 онд “CU” олон улсын конвiniенс сүлжээ дэлгүүрийг Монгол Улсын жижиглэн худалдааны салбарт нэвтрүүлэх Мастер франчайзийн гэрээг БНСУ-ын БиЖиЭф Ритэйл Ко., Лтд. (BGF Retail Co., Ltd.) компанитай хамтран амжилттай байгуулж Улаанбаатар хотод 6 сүлжээ дэлгүүртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

CU конвiniенс сүлжээ дэлгүүр 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Улаанбаатар хотод 285 салбар дэлгүүртэй болж үйл ажиллагаагаа улам тэлсээр байна.

ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ГОЛЛОХ
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэлгүүрийн тоо

285

Ажилчдын тоо

3,400+

CU алт хэрэглэгч

598
мянга

Өдрийн үйлчлүүлэгч

101,8+
мянга


Өдрийн борлуулалт

972
сая


Хувьцаа эзэмшигч

10,108


Салбарын тоо




CU апп хэрэглэгчдийн тоо (мянга)




Нэг сарын үйлчлүүлэгчдийн тоо (мянга)




Борлуулалтын орлого (тэрбум төгрөгөөр)



Татвар, шимтгэл төлөлт (тэрбум төгрөг)



Ажилтны тоо



Конвениенс сүлжээ дэлгүүр нь хэрэглэгчийн хамгийн ойр байршилд, хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлчилгээг бүх цагт нээлттэйгээр тасралтгүй хангаж ажилладгаараа онцлогтой.

**ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ОНЦЛОГ**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь CU конвениенс дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн ойр байрлах ая тухтай орчинд 24 цагийн турш санал болгохыг зорьдог.

Бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй хүргэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тогтмол өндөр түвшинд байлгахын тулд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал, ложистикийн, технологийн цогц шийдлийг бий болгож, нийгмийн дэд бүтцийн нэг хэсэг болон ажиллаж байна.



Nice to CU

OK PC



Конвиниенс сүлжээ дэлгүүр нь хэрэглэгчдийн хувьсан өөрчлөгдөж буй амьдралын хэв маягт тохирсон ая тухтай, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж, халуун хоол, уух зүйлс, хүнс болон цаг зав хэмнэсэн өдөр тутмын бусад бүтээгдэхүүн үйлчилгээг нэг дороос, хамгийн ойроос авах боломжийг олгодог. Энэхүү зорилгыг хангахын тулд компани 2022 онд дараах үндсэн 4 чиглэлд нийт 41.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийн, дэд бүтцээ тэлэх стратегийг баримтлан ажиллалаа. Үүнээс:

26.4
тэрбум

Ая тухтай
дэлгүүрийн
тэлэлт

5.5
тэрбум

Хоолны
үйлдвэрийн
шугам, Хүйтэн
хэлхээний
автоматжуулалт

6.1
тэрбум

Түгээлтийн
төвийн
өргөтгөл,
захиалга
бэлтгэлийн
автоматжуулсан
систем


3.3
тэрбум


Жижиглэн
худалдааны
Үндсэн
системийн
сайжруулалт



АЯ ТУХТАЙ ДЭЛГҮҮРИЙН ТЭЛЭЛТ

SU сүлжээ 2021 онд нийт 165 салбар дэлгүүрээр өдөр бүр 60,000 үйлчлүүлэгчид ая тухтай дэлгүүрийн үйлчилгээг үзүүлж байсан бол 2022 онд салбарын тэлэлтийг эрчимжүүлэн 120 салбар дэлгүүрийг нээснээр нийт 285 салбартай болов. Ингэснээр өдөр бүр 120,000 орчим үйлчлүүлэгч олон улсын стандартад нийцсэн хурдтай, ая тухтай, найрсаг үйлчилгээг авч байна.





Мөн 2022 оны IV улиралд Дархан хотод анхны салбараа нээснээр, Улаанбаатар хотоос гадагш тэлэх тэлэлтийн эхлэл тавигдсан. 2023 оны I улирлын байдлаар Дархан хотод 3 салбар, Баянчандмань сумд 1 салбартайгаар үйл ажиллагаа явуулж, Эрдэнэт хотод анхны салбараа нээхээр ажиллаж байна.

ХООЛНЫ ҮЙЛДВЭРИЙН АВТОМАТЖУУЛАЛТ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь СУ сүлжээний бүх салбарт өдөр бүр эрүүл, аюулгүй хоолыг үйлдвэрлэн хүргэх зорилгоор 2020 оны 11-р сард Баянзүрх дүүргийн Хонхор тосгонд 2,960м² талбайтай СУ хоолны үйлдвэрийг ашиглалтад оруулсан.

Улмаар 2022 онд үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх зорилгоор Аюулын дүн шинжилгээ ба Эгзэгтэй цэгийн хяналтын (Hazard Analysis Critical Control Point) болон Үйлдвэрлэлийн зохистой дадлын (Good Manufacturing Practice) тогтолцооны болзлыг хангаж, албан ёсоор сертификатжсан Монголын анхны нэг чигийн урсгалтай хоолны үйлдвэр болов.

Дэлгүүрийн тэлэлттэй уялдуулан үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөр хөнгөвчилсөн автоматажсан шугамуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлээд байна. Жишээлбэл, Монгол Улсад хамгийн анхны будаа боловсруулах шугамыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр үндсэн түүхий эд болох будааны амт чанар сайжрах, гарцыг нэмэгдүүлэх, хүнээс хамааралтай технологи ажиллагааны алдааг бууруулах зэрэг олон давуу талыг бий болгож байна.




ХҮЙТЭН ХЭЛХЭЭТ ТӨВИЙН ӨРГӨТГӨЛ

Хүйтэн хэлхээт түгээлтийн төв нь CU хоолны үйлдвэртэй зэрэгцэн байршдаг бөгөөд +4°C горим шаарддаг шинэхэн хоол, өндөг, сүү гэх мэт бүтээгдэхүүнийг хадгалах, бэлтгэх түгээх зориулалттай 600м² талбай бүхий зал, хөлдөөсөн бүтээгдэхүүн хадгалах, бэлтгэх зориулалттай -18-25°C орчинтой хөлдөөх өрөөнүүдтэй, агаар сэлгэлтийн бүрэн автомат удирдлагын системтэй дэд бүтэц юм.

Бид 2022 онд энэхүү түгээлтийн төвийн өргөтгөлийг ашиглалтад оруулж, бараа бэлтгэлийн хурдыг нэмэгдүүлэн, автоматжуулалтын Дижитал Ангилалтын Систем (Digital Assortment System)-ийг амжилттай нэвтрүүлснээр, цаашид 440 CU дэлгүүрт дээрх төрлийн шинэхэн бүтээгдэхүүнийг өдөр бүр 2-3 удаа бэлтгэн түгээх хүчин чадалтай болоод байна.

Тус төвд CU хоолны үйлдвэрээс бэлтгэгдэн гарч буй хоолнуудаас гадна дотоодын бусад үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг хүлээн авч, өдөрт дунджаар 100,000 ширхэг бүтээгдэхүүнийг бэлтгэн шөнийн цагаар түгээж байна. Температурын тусгай горим шаарддаг бүтээгдэхүүнүүдийг бэлтгэн түгээхдээ бид хадгалалт, тээвэрлэлтийн үеийн температурыг зориулалтын автомат дата-логгер ашиглан хэмждэг тул бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн гарт хүртэл бүрэн хянах боломж бүрдэж байна.



ЗАХИАЛГА БЭЛТГЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ

Бид Баянгол дүүрэгт байрлах түгээлтийн төвөө 2022 онд өргөтгөн 5,200м² талбайтай болгосноор цаашид 650-700 хүртэл CU дэлгүүрийн захиалгыг өдөр бүр бэлтгэн гаргах хүчин чадалтай боллоо. Мөн бид төлөвлөгөөний дагуу БНСУ-ын Asetec брэндийн захиалга бэлтгэх хагас автомат Дижитал бараа бэлтгэлийн систем (Digital Picking System)-ийг нэвтрүүлж Агуулахын нэгдсэн удирдлагын систем (Warehouse Management System)-тэй бүрэн интеграци хийж автоматжууллаа. Энэхүү автомат системийг нэвтрүүлснээр бид дэлгүүрийн захиалгыг 2 дахин хурдан, 99 хувийн оновчлолтой бэлтгэх боломжтой болж байна.



ҮНДСЭН СИСТЕМИЙН САЙЖРУУЛАЛТ

Компани 2022 онд компанийн алба, хэлтэс, салбар дэлгүүр, түгээлтийн төв болон хоолны үйлдвэр зэрэг дотоод үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, бараа бүтээгдэхүүний урсгалыг хурдтай, оновчтой явуулах, улмаар үйлчлүүлэгчиддээ өгөх конвениенс дэлгүүрийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ компанийн өрсөлдөхүйц шинэ давуу талыг бий болгох зорилгын хүрээнд “Global IT System” нэвтрүүлэлтийн төслийг 1-р сараас эхлэн нийт 9 сарын хугацаанд амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Төслийн хугацаанд компанийн төв оффисын нийт газар, хэлтсүүдийн төлөөллөөс бүрдсэн төслийн баг томилогдон, төслийн гол хамтрагч байгууллагаар CU мастер франчайз эрх олгогч BGF Retail компанийн мэргэжлийн зөвлөх баг хамтран ажиллаж, бид төлөвлөсөн хугацаандаа төсөвтөө багтаан амжилттай хэрэгжүүлж дууслаа. Төслийн хүрээнд төв оффис, дэлгүүр, түгээлтийн төв гэсэн гурван түвшинд нийт 30,000 орчим хүн/цагийг зарцуулсан байна.

Бизнесийн ноу-хау, дата мэдээллийн урсгал, систем хэрэглэгчийн эрх үүргийн зохистой хуваарилалт, дэлгүүрийн ПОС-ын үйлчилгээний сайжруулалт болон олон төрлийн урамшуулал, хөтөлбөрүүдийг системээр дамжуулах боломж зэрэг нь системийн үндсэн давуу тал болж, бидний цаашид хийж хэрэгжүүлэх олон ажлын сайн суурь болж, бид мэдээллийн системийн дэд бүтцээ дахин нэг шатаар ахиуллаа.



ТҮҮХЭН АМЖИЛТУУД

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь СУ конвениенс сүлжээ дэлгүүрийн бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлснээр уламжлалт найман нэрийн хүнсний дэлгүүрийн үйлчилгээг шинэ түвшинд гаргаж, хэрэглэгчид олон улсын стандартад нийцсэн цэвэр цэмцгэр, тохилог орчинд өөрт хэрэгцээт бүтээгдэхүүнийг сонгон үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлээд байна. Энэ нь Монгол Улсын жижиглэн худалдааны салбарын хөгжлийг урагшлуулсан алхам болсон юм.

2022 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

2015 он



Сэнтрал Экспресс нэртэй Монголын хамгийн анхны конвениенс сүлжээ дэлгүүрийн суурийг тавив.

2015 он

2017 он



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг үүсгэн байгуулав.

2017 он

2018 он



БНСУ-ын БиЖиЭф Ритэйл компанийн мастер франчайз эрхийг Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК хүлээн авав.

Монгол улсын "Анхны ая тухтай" дэлгүүр MNS гэрчилгээ авав.

2018 он

2019 он



CU брэнд 50 салбар дэлгүүртэй болов.

Нэг өдөрт үйлчлүүлэгчдийн тоо 30,000 -д хүрэв.

Монголын хамгийн анхны гар утасны аппликейшнд суурилсан үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр "CU App"-ийг нэвтрүүлэв.

2020 он



4,200 м² энгийн температурын горимтой түгээлтийн төвийг ашиглалтад оруулав. Петровис ШТС-уудад салбар дэлгүүрүүд нээв. Монголын ТОП-100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарав.

Монголын хамгийн хурдан буюу 30 минутын дотор хүргүүлэх "CU Хүргэлтийн үйлчилгээ"-г нэвтрүүлэв. CU салбар дэлгүүрийг франчайзийн эрхээр жижиг дунд бизнес эрхлэгчдэд эзэмшүүлж эхлэв.

Монголын хамгийн анхны 100 салбар дэлгүүртэй сүлжээ болов.

Монголын хамгийн анхны хүнсний аюулгүй байдлын олон улсын GMP, HACCP стандартыг хангасан хоолны үйлдвэрийг байгуулж, ашиглалтад оруулав.

2021 он



CU App 415 мянган гишүүнтэй болов.

CU брэнд 165 салбар дэлгүүртэй болов.

CU брэнд НҮБ-ын хүүхдийн сантай хамтран "Байгальд ээлтэй Монгол гэр" төслийг хэрэгжүүлж эхлэв.

ЦЕГ-ын Хүүхэд хамгааллын хэлтэстэй хамтран "CU ЧАМД ТУСАЛТЪЯ" төслийг хэрэгжүүлж эхлэв. Олон нийтэд нээлттэй хувьцаат компани болов..

2019 он

2020 он

2021 он

ТАЙЛАНТ ҮЕИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“Хэрэглэгчийн үйлчилгээгээр дэлхийд танигдана” гэсэн том мөрөөдөл дор нэгдсэн манай хамт олон CU конвениенс дэлгүүрийн шинэлэг, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, чин сэтгэлийн найрсаг үйлчилгээ, хялбар шийдлүүдээрээ дамжуулан эх орондоо ажиллаж амьдрахад урамтай, соёлтой, аюулгүй нийгмийг бүтээлцэж чадна гэж итгэдэг.

2022 он



CU брэнд Мобикомын хамтарсан шинэ салбар нээлтээ хийлээ.

Амттан идэх дуртай залуустаа зориулан Кастард Бан буюу Шанзтай мантуун буузыг Монголд анх удаа гаргав.

2022 он



Засгийн газрын шийдвэрийн дагуу CU ая тухтай дэлгүүрийн салбарууд 24 цаг ажиллаж эхэллээ.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Сиркл Чейн ХХК-ийн Circle K сүлжээ дэлгүүрийн 12 салбарыг худалдан авах хэлцэлд гарын үсэг зурав.

CU сүлжээ дэлгүүр DUDU-гээ аварья аянд нэгдлээ.

2022 он



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулав.

Нэг өдрийн борлуулалт 1 тэрбум төгрөгт хүрэв.

Хүний нөөцийн бодлогоороо манлайлагч шилдэг ажил олгогч шагналыг хүртлээ.

CU 200 дах салбар дэлгүүрээ нээв.

440 дэлгүүрт өдөр бүр 2-3 удаа түгээх зориулалттай хүйтэн хэлхээний түгээлтийн төвийн өргөтгөлийн ажил эхлүүлсэн

2022.1

2022.1

2022.11

2022 он



МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 05-р сарын 05-ны өдрийн А/42 тоот тушаалаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн үнэт цаасны ангиллыг ахиулан II дугаар ангилалд бүртгэсэн.

Монголын ТОП-100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарав.

CU конвiniенс дэлгүүр үйлчилгээний хүрээгээ тэлж Налайх дүүрэгт шинэ салбараа нээсэн.

2022.II

2022 он



CU брэнд Плэйтайм 2022 фестивалийн стратегийн түнш, албан ёсны конвiniенс дэлгүүр болж хамтран ажиллахаар боллоо.

БНСУ-ын нөү хау шингэсэн цогц мэдээллийн систем "GLOBAL IT SYSTEM"-ийг нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлж нийт дэлгүүрийн хэмжээнд бүрэн гүйцэтгэж дууссан.

CU сүлжээ дэлгүүр 00:00-07:00 цагийн хооронд 18 хувиас өндөр спиртийн агууламжтай согтууруулах ундааг худалдаалахгүй байх шийдвэрийг гаргалаа.

CU Самбуугийн гудамж салбарт шинэ үйлчилгээ буюу хурал уулзалтын өрөөтэй боллоо.

2022.III

2022он



Нийслэлийн Засаг даргын тамгын газар CU сүлжээ дэлгүүртэй хамтарч ажиллахаар болов.

11-р сарын 24-ний өдөр анхны орон нутагт буюу Дархан хотод салбар дэлгүүрээ нээсэн.

2022.IV

2023 он



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК МХБ-ийн ТОП 20 индексийн сагсанд шинээр нэмэгдсэн.

300 дах салбар дэлгүүрээ амжилттай нээсэн.

Франчайз хөтөлбөрөө зарласан.

SU Хоол үйлдвэрлэлийн төв нь олон улсын хүнсний аюулгүй байдлын НАССР стандартын гэрчилгээтэй Монголын хамгийн анхны бэлтгэсэн хоолны үйлдвэр болсон.

Монгол Улсад анх удаа жижиглэн захиалга бэлтгэх хагас автомат (pick-to-light) системийг нэвтрүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Хүнсний Хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Хоол үйлдвэрлэлийн төв, түгээлтийн төв болон компанийн нийт үйл ажиллагаатай танилцсан.

Төв аймгийн Баянчандмань суманд SU289 “Баянчандмань” салбараа амжилттай үүд хаалгаа нээсэн.



2023.I

CU

URBAN
FEEL



ub bikers

ub bikers


СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛ

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

Бид хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй амьдралын хэв маягт тохирсон хоол, хүнс болон бусад өдөр тутмын үйлчилгээг нэг дороос, хамгийн ойроос, ая тухтай орчинд түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэхийн төлөө ажилладаг.

Цаашид бид хэрэглэгчдэдээ илүү ойр байршиж, илүү оновчтой бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх зорилтдоо хүрэхийн тулд дараах стратегийг дунд хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

ӨСӨЛТИЙН СТРАТЕГИ



ЗАХ ЗЭЭЛД ДАВАМГАЙЛАХ

Конвiniенс дэлгүүр нь хэрэглэгчид хамгийн ойр байдаг үйлчилгээний дэд бүтцийн үүргийг гүйцэтгэдэг. CU конвiniенс сүлжээ дэлгүүр нь зөвхөн бараа бүтээгдэхүүн борлуулахаас гадна GoPower зөөврийн цэнэглэгчийн үйлчилгээ, АНУ-с шууд бүтээгдэхүүн захиалан авах боломжтой StoraBox үйлчилгээ зэрэг хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй амьдралын хэв маягт нийцсэн бусад үйлчилгээг хэрэглэгчид нэг цэгээс 24 цагийн турш хүргэх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Үнэгүй интернэт



Хүүхэд хамгаалал



Ариун Цэврийн өрөө



Хамгийн
хүртээмжтэй
үйлчилгээ

CU конвiniенс дэлгүүр нь хэрэглэгчид хамгийн ойр буюу орон сууцны хороолол, оффис, эмнэлэг, сургууль, автобусны буудал, нисэх буудал, автовокзал зэрэг хүн амын хөдөлгөөний урсгал ихтэй байршлуудад нэвтэрсэн нь Улаанбаатар хотын хамгийн өргөн хүрээний дэд бүтцийг бий болгож байна.

Түргэн хоол

17

Кофе шоп

32

Эмийн сан

86

Үүрэн холбоо

29

Банк

69

Салбартаа тэргүүлэгч
компаниудын УБ хот дахь
салбарын тоо

CU


285

Бид иргэдэд хэрэгтэй үйлчилгээг ойртуулах, бизнесийн өсөлтийг тогтвортой хадгалах зорилгынхоо хүрээнд 2022 онд 120 дэлгүүр шинээр нээж нийт 285 дэлгүүртэй болсон.

**СУ БРЭНД
CIRCLE-K
СҮЛЖЭЭНИЙ
12 САЛБАРЫГ
ШИЛЖҮҮЛЭН
АВСАН**

SU конвениенс дэлгүүрийн мастер франчайз эрх эзэмшигч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (МХБ: CUMN) нь Сиркл Чейн ХХК-ийн Circle-K сүлжээ дэлгүүрийн 12 салбарыг худалдан авах хэлцэлд гарын үсэг зурж баталгаажуулж авсан. 2021 оны 12-р сард хоёр тал хэлэлцээрээ эхлүүлсэн бөгөөд 2022 оны 1-р улиралд тохиролцоонд хүрснээр тус 12 байршилд SU конвениенс дэлгүүрүүд үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

2023 оны эхний 3 сард 15 дэлгүүр шинээр нээж нийт 300 дэлгүүртэй болоод байна. УБ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөдөө орон нутаг, авто замын гол зангилаа цэгүүд болон шинэ суурьшлын бүсүүдийг судалж 2022 онд Монгол улсын хоёр дах том хот болох Дархан хотод орон нутгийн анхны конвениенс дэлгүүрийг нээн ажиллуулж байна.



Орон нутагт конвениенс дэлгүүр нээгдсэнээр иргэд сэтгэл хангалуун байгаа нь тухайн бүсэд SU дэлгүүр нээгдэх хэрэгцээ болон хүлээлт аль хэдийн үүссэн байгааг илтгэж байна. Улаанбаатар хотын дагуул хот, тосгод суурин газрыг хөгжүүлэх бодлогын хүрээнд хүн амын төвлөрөл өндөртэй бүс нутаг, тосгон суурин газруудад конвениенс дэлгүүрийн хэрэгцээ өндөр байх магадлалтай байршлуудыг тогтоогоод байгаа бөгөөд 2023 оны эцэст нийт 365 байршилд SU дэлгүүрийг нээхээр зорин ажиллаж байна.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

CU конвينيенс дэлгүүр хэрэглэгч үйлчлүүлэгчдийнхээ цаг завьг хэмнэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг олон байршлаас хүргэх зорилгын хүрээнд Петровис Групптэй хамтран 18 шатахуун түгээх газруудад CU дэлгүүрийг нээн ажиллаж байна. Олон улсад шатахуун түгээх газруудад суурилсан конвينيенс дэлгүүрийн хэрэгцээ шаардлага маш эрэлттэй байдаг төдийгүй автомашинтайгаа олон цагийг өнгөрүүлж, ажил амьдралаа зохицуулж буй манай улсын иргэдийн хувьд ч цаг үеэ олсон үйлчилгээ болж байна.

2021 оны 9-р сард CU, Мобиком Корпорацитай хамтарсан анхны салбараа Содон хороололд нээж байсан бол удаах төв нь Теди-2 худалдааны төвд нээгджээ. Цаг завьг хэмнэж, ая тухьг мэдрүүлэх тус салбараас Мобикомын бүх төрлийн үйлчилгээг авахын зэрэгцээ CU-н халуун кофег амталж, хэрэгцээт бүтээгдэхүүнээ авах боломжтой.



ФРАНЧАЙЗ ХӨТӨЛБӨР

Бид 2023 оны 03-р сарын 07-ны өдөр СУ брэндийн 300 дах салбарын нээлтээ хийхийн сацуу хувийн бизнестэй болох хүсэлтэй иргэд болон бизнесийн цар хүрээгээ тэлэх сонирхолтой жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан франчайз хөтөлбөрийг олон нийтэд нээлттэй зарласан. Энэхүү хөтөлбөрийн дагуу франчайз эрх хүсэгч нь СУ сүлжээ дэлгүүрүүдээс борлуулалт, үйл ажиллагаа нь тогтворжиж, үйлчлүүлэгчдэдээ танигдсан байршлуудаас сонгон, өөрийн бизнес болгон авах боломжтой.

Уг хөтөлбөрөөрөө дамжуулан бид бизнес эрхлэгчидтэй урт хугацаанд, харилцан ашигтай байдлаар хамтдаа үнэ цэнэ үүсгэж хамтарч ажиллах зорилготой юм. Бид франчайз хамтрагчдадаа “бизнес инкубатор”-ын үүргийг гүйцэтгэх бөгөөд СУ сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагааг дэмжин ажиллах нэгдсэн үйлчилгээгээрээ хамтран ажиллах болно. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн хүрээнд бизнесийн ноу хау, дата шинжилгээний өргөн боломжууд, нэгдсэн түгээлтийн үйл ажиллагаа, мерчандайзинг болон бүтээгдэхүүн хөгжүүлэлт, төвлөрсөн брэндинг ба сурталчилгаа гэсэн конвиниенс бизнесийн үндсэн давуу талуудыг франчайз хамтрагчдадаа бий болгож ажиллана.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь анх 2020 оны 6-р сард франчайз хөтөлбөрийг компанийн бизнесийн өсөлтийг хурдасгах зорилгоор эхлүүлж байсан бөгөөд удалгүй КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр хөтөлбөрийг түр зогсоосон. Харин 2023 оноос эхлэн франчайз хөтөлбөрөө тасралтгүй хийж хэрэгжүүлэхэд чиглэн ажиллана.



БОСОО ИНТЕГРАЦ

Түгээлтийн төвүүд

**ӨДӨРТ
2-3 УДАА**

Нэг дэлгүүрт бараа
ханган нийлүүлдэг

CU конвениенс сүлжээ дэлгүүрээр борлуулах бүтээгдэхүүнийг бид өөрсдийн түгээлтийн системээр дамжуулан, нэгдсэн удирдлагаар хангаж өдөр бүр түгээснээр дэлгүүрүүд хэрэглэгчийн үйлчилгээний чанартаа илүү анхаарч, дэлгүүрийн зай талбайг хамгийн үр ашигтай байлгаж нэгж метр квадрат талбайгаас хамгийн өндөр борлуулалтыг хийх боломж олгодог билээ.

CU дэлгүүрийн тэлэлт, бизнесийн стратегитай уялдуулан Түгээлтийн төвүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, боломжит үйл ажиллагааг автоматжуулан ажиллаж байна.

Одоогийн байдлаар бид 500 орчим дотоодын бэлтгэн нийлүүлэгчийн 2,400 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг горимын дагуу хүлээн авч, хадгалж, өдөр бүр 300 гаруй салбар дэлгүүрт 400 мянган ширхэг бүтээгдэхүүн бэлтгэн түгээж байна. Бид үндсэн түгээлтээ УБ хотын замын хөдөлгөөн багатай цагаар буюу орой 22 цагаас эхлэн өглөө 8 цаг хүртэл гүйцэтгэж байна. Компанийн түгээлтийн дэд бүтэц нь дараах хэсгүүдээс бүрддэг.

ХЭВИЙН ТЕМПЕРАТУРЫН ГОРИМТОЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТҮГЭЭЛТИЙН ТӨВ

Бид Баянгол дүүрэгт байрлах түгээлтийн төвөө 2022 онд өргөтгөн 5,200 м² талбайтай болгосноор цаашид 650-700 хүртэл CU дэлгүүрийн захиалгыг өдөр бүр бэлтгэн гаргах хүчин чадалтай болж байна. Мөн бид төлөвлөгөөний дагуу БНСУ-ын Asetec брэндийн захиалга бэлтгэх хагас автомат DPS системийг нэвтрүүлж Агуулахын нэгдсэн удирдлагын систем (WMS)-тэй бүрэн интеграци хийж автоматжууллаа. Энэхүү автомат системийг нэвтрүүлснээр бид дэлгүүрийн захиалгыг 2 дахин хурдан, 99 хувийн оновчлолтой бэлтгэх боломжтой болж байна.



ХҮЙТЭН ХЭЛХЭЭТ ТҮГЭЭЛТИЙН ТӨВ

Хүйтэн хэлхээний түгээлтийн төв нь $+4^{\circ}\text{C}$ горим шаарддаг шинэхэн хоол, өндөг, сүү гэх мэт бүтээгдэхүүнийг хадгалах, бэлтгэх, түгээх зориулалттай 600m^2 талбай бүхий зал, хөлдөөсөн бүтээгдэхүүн хадгалах, бэлтгэх зориулалттай -18°C -ээс -25°C орчинтой хөлдөөх өрөөнүүдтэй, агаар сэлгэлтийн бүрэн автомат удирдлагын системтэй дэд бүтэц юм. Бид 2022 онд энэхүү түгээлтийн төвийн өргөтгөлийг ашиглалтад оруулснаар цаашид 440 CU дэлгүүрт дээрх төрлийн шинэхэн бүтээгдэхүүнийг өдөр бүр 2-3 удаа бэлтгэн түгээх хүчин чадалтай болгож байна.

Тус төвд CU хоолны үйлдвэрээс бэлтгэгдэн гарч буй хоолнуудаас гадна дотоодын бусад үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг хүлээн авч, өдөрт дунджаар 100 мянган ширхэг бүтээгдэхүүнийг бэлтгэн шөнийн цагаар түгээж байна. Температурын тусгай горим шаарддаг бүтээгдэхүүнүүдийг бэлтгэн түгээхдээ бид хадгалалт, тээвэрлэлтийн үеийн температурыг зориулалтын автомат дата-логгер ашиглан хэмждэг тул бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн гарт хүртэл бүрэн хянах боломж бүрдэж байгаа юм.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 2020 оны 11-р сард Баянзүрх дүүргийн Хонхор тосгонд 2,960 м² талбайтай СИ хоолны үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Тус үйлдвэр нь СИ конвинеенс дэлгүүрт савласан хоолыг нийлүүлдэг бөгөөд хүнсний аюулгүй байдлын олон улсын Аюулын дүн шинжилгээ ба Эгзэгтэй цэгийн хяналтын (Hazard Analysis Critical Control Point) болон Үйлдвэрлэлийн зохистой дадлын (Good Manufacturing Practice) тогтолцооны болзлыг хангасан Монголын анхны нэг чиглэлийн урсгалтай нийтийн хоолны үйлдвэр юм.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

Хоолны үйлдвэр нь 20 нэр төрлийн, 30 мянган ширхэг бэлэн бүтээгдэхүүнийг хүнсний нэмэлтгүйгээр үйлдвэрлэдэг. Бид дотоодын 38 бэлтгэн нийлүүлэгчдээс сар бүр 900 сая төгрөгийн худалдан авалтыг тогтмол хийсэн нь тэдгээр жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа өргөжүүлэх боломжийг нь нэмэгдүүлсэн. Үйлдвэрийн барилгын давуу тал нь хүнсний үйлдвэрлэл болон хөргөх, хөлдөөх агуулахыг зориулалтын EPS, полиуретан хавтангаар хийсэн нь нян бактери үржихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэнд оршдог.

Хоол үйлдвэрлэлийн төв бүрэн хүчин чадлаараа ажиллан 2022 оны 4-р улирлаас эхлэн СИ конвинеенс дэлгүүрүүдийн захиалгыг бүрэн буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй үйлдвэрлэж эхэлсэн. Улмаар үйлдвэрийн бүтээгдэхүүний өдрийн дундаж гарцыг мөн өмнөх оноос 2 дахин нэмэгдүүлсэн. Бүтээгдэхүүний гарц өдрийн дундаж 26,238 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

2021 онд 3.6 сая, 2022 онд 7.4 сая ширхэг бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэсэн бөгөөд 2023 онд 14.6 сая ширхэг бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна. 2022 онд СИ конвинеенс дэлгүүрийн тэлэлттэй уялдуулан үйлдвэр бүтээмжийг нэмэгдүүлж хөдөлмөрийг хөнгөвчилсэн, автоматжуулсан тоног төхөөрөмж болон процессыг нэвтрүүлсэн. Жишээ болгон дурдвал, Монгол Улсад хамгийн анхны будаа боловсруулах шугамыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр үндсэн түүхий эд болох будааны амт чанар сайжрах, гарцыг нэмэгдүүлэх, хүнээс хамааралтай технологи ажиллагааны алдааг бууруулах зэрэг олон давуу талуудыг бий болгож байна.

Хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн бүтээгдэхүүнийг бий болгохын тулд 2022 онд сар бүр 33,000 хүн цаг буюу өмнөх оноос 28,512 хүн цагийн шинэ ажлын байрыг бий болгон ажилласан байна. Мөн үйлдвэрийн ажилчдын 68 хувь нь Налайх дүүргээс ажилладаг.






ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Налайх болон Баянзүрх дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих зорилготой ажлын байраар хангах өдөрлөгүүдэд идэвхтэй оролцож ажлын байраар ханган ажиллаж байна.
- Үйлдвэрийн ажилчдын мэргэжил, ур чадварыг сайжруулах зорилгын хүрээнд Хүнсний технологийн коллежтой хамтран сургалтын төлбөрийн тодорхой хэмжээг Компаниас хариуцаж мэргэжил боловсролыг дээшлүүлэхэд анхааран ажилласан.
- Их дээд сургууль, Политехникийн коллежтой хамтран хүнсний салбарын оюутнуудыг үйлдвэрт дадлага хийлгүүлж сургуулиудтай хамтын ажиллагаатай ажиллаж байна.
- Үйлдвэр нээгдсэн цагаас хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллаж үйлдвэрийн осол гэмтэл гаралгүй 1.6 сая цаг ажилласан байна.
- БЗД-ийн 11-р хороотой хамтран “Эрүүл хоггүй орчинд угтъя” аянд оролцон ойр орчмын нутаг дэвсгэрийн хогийг цэвэрлэсэн.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯЛГАРАЛ

CU конвениенс дэлгүүр өөрийн нэрийн, үндэсний үйлдвэрлэгчидтэй хамтран хөгжүүлсэн болон импортын шинэлэг тренд бүтээгдэхүүнийг үнийн уян хатан бодлого баримтлан хэрэглэгчдэд санал болгож, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлж байна.



Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөрт байлгаж, үйлчилгээний стандартыг алдагдуулахгүйн тулд дэлгүүрийн стандартын нийцлийн үнэлгээ болон чанарын хяналт, зөрчлийн залруулгын удирдлагын QSC системийг ашигладаг.

ҮЙЛЧИЛГЭЭ – ОНЦГОЙ САЛБАР

Тухайн бүсийн онцлогтой уялдуулан иргэдийн хэрэгцээг хангах үүднээс нярай хүүхэд хуурайлах хэсэг, хүүхдийн тоглоомын хэсэг, хурал уулзалтын өрөө зэрэг шинэлэг концепцтой 3 дэлгүүрийг нээн ажиллаж байна. Хэрэглэгчдэд илүү таатай, хэрэгцээтэй үйлчилгээг үзүүлэхээр CU Самбуугийн гудамж салбар хурал уулзалтын өрөөг тохижуулсан. Үйлчлүүлэгчид өдрийн аль ч цагт ирээд ая тухтай орчинд ажил уулзалтаа хийх боломжтойгоороо онцлог юм.

ХАМТЫН АЖИЛЛАГАА


Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь өөрийн хоол үйлдвэрлэл болон бусад гэрээт байгууллагуудтай хамтран хэрэглэгчдэд зориулан шинэ бүтээгдэхүүн боловсруулж онцгой эрхтэйгээр худалдан борлуулдаг. 2022 онд 22 нийлүүлэгчийн 57-н хоолны нэр төрлийн бүтээгдэхүүнийг шинээр хамтран хөгжүүлж нэвтрүүлсэн. Хэрэглэгчдэд шинээр Хавай Мүсүби (2 төрөл), шинэ төрлийн гурвалжин кимбаб, эрүүл зутан шөл, пирошки, хуушуур, догбуги, үхрийн махтай үдон, тахиан махтай жолмён гоймон, 2 төрлийн шарсан тахиа, хөвсгөр бан (кастардтай), 3-н төрлийн салат, тахианы цээж махан котлет, 2 төрлийн буррито, ояакодон, бибимбаб, калбижим, веган котлет, веган амталсан будаатай хуурга гэх мэт шууд хэрэглэх хөргүүрийн болон халуун хоолны бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлсэн.



2021 онд 18 гэрээт нийлүүлэгч бэлэн бүтээгдэхүүний нийлүүлэлт хийж байсан бол 2022 онд 22 нийлүүлэгч бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн. 2022 онд бэлтгэн нийлүүлэгчдийн борлуулалт 2021 онтой харьцуулахад 2.74 дахин нэмэгдсэн.

Бэлтгэн нийлүүлэгчдийг чадавхжуулах ажлын хүрээнд “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг бэлтгэн нийлүүлэгч нарын дунд хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд Обзерв Консалтинг ХХК-тай хамтран гэрээт 10 нийлүүлэгчийг Хоол үйлдвэрлэлийн гинжин хэлхээг сайжруулах болон Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP, GHP) нэвтрүүлэх сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Сургалтад хамрагдсан 10 нийлүүлэгчээс 8-н нийлүүлэгч “Хамтдаа хөгжье-2” буюу НАССР тохирлын гэрчилгээ авах сургалтад үргэлжлүүлэн хамрагдаж байна.



2022 он

Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ

Компани нь 2022 онд 1,615 бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлсний 208 нэр төрлийн бүтээгдэхүүнийг БНСУ, Япон, Польш зэрэг орнуудаас импортолсон бөгөөд Компанийн 2022 онд импортолсон бүтээгдэхүүний борлуулалт 2021 оны борлуулалтаас 2.77 дахин өссөн байна.

Компани нь шууд импорт хийхээс гадна нийлүүлэгч байгууллагуудтай хамтран зөвхөн өөрийн сүлжээ дэлгүүрээр худалдаалах зорилготой дэлхийн брэнд бүтээгдэхүүнийг импортолдог бөгөөд дэлхийн спорт ус, ундааны номер 1 брэнд Gatorade спорт ундаа, дэлхийн алдартай зайрмагийн брэнд Baskin Robbins-ыг Монголын зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 2023 оны 1-р улиралд 188 бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлсэн байна.



Дэлхийн хамгийн том зайрмаг үйлдвэрлэгч болох Baskin Robbins-ын бүтээгдэхүүнийг Монголдоо анх удаа зөвхөн СУ-д 2022 Оны 11-р сараас худалдаалж эхэлсэн

Европын алдарт Hitchens брэндийг Монголд анх удаа СУ өөрийн салбараар худалдаалан хэрэглэгчид таниулсан



Бурамхан



Нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж Бурамхан брэндийн бүтээгдэхүүнийг нэмэлт хөгжүүлэлтийг хийн бүх салбартаа амжилттай борлуулж байна



Негуроо чанасан өндөг



Будааны ороомог



Korean toast sandwich



Шингэн сүүтэй GET Latte нэвтэрсэн.



Цөлдөвдлийг хоол үйлдлийн хоол нийцсэн олон улсын стандартад нийцсэн

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ

Ая тухтай дэлгүүр нь хүний бараа бүтээгдэхүүн худалдан авах хэрэгцээг хангаад зогсохгүй сим карт авах, гар утасны нэгж цэнэглэх, төлбөр төлөх, баримт бичиг хэвлэх, олшруулах, шуудан илгээмж илгээх, хүлээн авах, төрийн болон банкны зарим үйлчилгээг авах, жуулчдад мэдээлэл өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлдэг болоод байна.

CU конвениенс сүлжээний хувьд ч мөн адил эдгээр үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлж, хэрэглэгчдэдээ улам илүү үнэ цэнийг бий болгохыг зорин ажиллаж байгаа бөгөөд 2021 онд CU дэлгүүрт сим карт авах болон онлайн худалдааны Stora box үйлчилгээнүүдийг шинээр нэвтрүүлж, дэлгүүртээ байрших АТМ-ийн тоог нэмэгдүүлснээс гадна 2022 онд нийт 285 салбар дэлгүүртэй болсноор Улаанбаатар хотын нийтэд нээлттэй ариун цэврийн өрөөний тоог нэмэгдүүлээд байна.



ҮНЭНЧ ХЭРЭГЛЭГЧИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

CU конвениенс дэлгүүрийн “Сайн байна уу? CU-д тавтай морил” хэмээн мэндчилэх зэрэг бидний үйлчилгээний соёл нь хэрэглэгчдэд хэдийн танигдсан бөгөөд Улаанбаатар хотын үйлчилгээний стандартыг нэг шат ахиулж урт хугацааны үнэ цэнийг бүтээсэн. Бид чанар, үйлчилгээ, ариун цэврийн стандартыг үйл ажиллагаандаа өдөр бүр мөрдлөг болгон ажилладаг. Бид дэлгүүрийн ажилтнуудыг тогтмол сургаж хөгжүүлэх, урамшуулах, карьер өсөлтийг нь дэмжих замаар стандартыг тогтвортой хадгалж, Монголын хамгийн сэтгэлд ойр үйлчилгээтэй дэлгүүр байхыг зорин ажилласаар байна.

**НАЙРСАГ
ДОТНО
ҮЙЛЧИЛГЭЭ**



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь шилдгийн шилдэг ажил олгогчийг шалгаруулах “GOOD WORKPLACE AWARDS 2022” арга хэмжээнээс “Good Workplace with Best Leadership in HR Policy” буюу “Хүний нөөцийн бодлогоороо манлайлагч шилдэг ажил олгогч” шагналыг хүртсэн.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь жил бүр ажилтнуудынхаа сэтгэл ханамж, оролцоог олон улсын Gallup-ийн судалгааны аргачлалыг ашиглан судалж, судалгааны үр дүнд суурилсан идэвхжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг.

Мөн зан хандлагын болон мэргэжлийн өрсөлдөх чадамж дээр суурилсан босоо буюу удирдах, хөндлөн буюу мэргэшлээ хөгжүүлэх чиглэлд карьер хөгжих боломжтой системийг амжилттай нэвтрүүлэн 2022 онд нийт 1,112 ажилтан карьерын босоо болон хөндлөн чиглэлд ахиж дэвшсэн үзүүлэлттэй ажиллаж байна.



Үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр нь лоялти оноогоор шагнах, худалдан авалтын давтамжид суурилсан урамшуулал олгох, хувь хэрэглэгчийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох замаар урт хугацаанд хэрэглэгчид хүрэх үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд CU аппликэйшнээр дамжуулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2022 оны 12-р сарын 31-ны байдлаар CU аппликэйшн дараах үзүүлэлттэй ажиллаж байна.



Үнэнч хэрэглээг дэмжих зорилготой CU лоялти аппликэйшнийг сар бүр 116 мянга орчим үйлчлүүлэгч идэвхтэй ашиглаж байна. Эдгээр хэрэглэгчдэдээ илүү үнэ цэнийг хүргэх зорилгоор урамшууллын Купон үйлчилгээг хөгжүүлэн 2022 оны 5-р сард нэвтрүүллээ. Улмаар үнэнч хэрэглэгчид маань тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүний давтан худалдан авалт бүрээ тоолуулж, даалгавар биелүүлснээр үнэ төлбөргүй нэмэлт бүтээгдэхүүнийг шагналд авах боломж бүрдэж байна.

CU app анх хэрэглээнд нэвтэрсэн үеэс хойш буюу 2019 оны 10-р сараас 2023 оны 3-р сар хүртэлх хугацаанд 243,886 шагналын болон сугалааны купон үүссэн байна. Үүнээс 107,404 нь урамшууллын купон байсан бөгөөд 25,722 үнэгүй бүтээгдэхүүнийг үнэнч хэрэглэгчдэдээ бэлэглэсэн. Мөн 2022 онд 89,977 хэрэглэгч сугалаатай урамшуулалд хамрагдсан байна.



Check-in урамшуулал

CU сүлжээ дэлгүүрийг өдөр бүр сонгон үйлчлүүлж буй үнэнч хэрэглэгчдээ урамшуулах зорилгоор Check-in урамшууллыг шинээр нэвтрүүллээ. Тус урамшууллын хүрээнд хэрэглэгч тухайн сард үйлчлүүлсэн давтамжаас хамааруулан өндөр эрэлттэй американо, латте кофе зэрэг төрөл бүрийн бүтээгдэхүүнийг шагналд авах боломжтой боллоо.


Сар бүрийн онцлогт тохируулан тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнийг N+1 нөхцөлөөр буюу худалдан авалт бүрээ бүртгүүлэн, нэмэлт бүтээгдэхүүнийг шагналд авах боломжийг CU апп дээр тулгуурлан явуулж эхэллээ. Эдгээр функцүүдийн тусламжтай бид хэрэглэгчдэдээ шинэлэг байдлаар урамшуулал олгох, үнэнч хэрэглэгчдийн тоог чанартайгаар нэмэгдүүлэх олон нэмэлт боломжийг бий болголоо.



Купон үйлчилгээ

ТЕХНОЛОГИЙН ЦОГЦ ШИЙДЭЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь өдөр тутмын үйл ажиллагаандаа технологийн дэвшилтэд шийдлийг ашиглан бараа бүтээгдэхүүний оновчтой удирдлагыг хэрэгжүүлэхээс гадна хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг өгөгдөлд суурилсан судалгаа шинжилгээгээр нээн илрүүлж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тогтмол хийдэг.



ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ

Бид хэрэглэгчдэдээ үргэлж хурдтай, тав тухтай, амар хялбар үйлчилгээг хүргэхийг зорьж, нийтийн хэрэглээнд түгээмэл нэвтэрсэн төлбөрийн хэрэгслүүдийг төлбөр тооцооны системдээ холбосоор байна. CU конвениенс дэлгүүр нь SocialPay, Mon-pay, QPay, Mongolchat, Hipay, Toki Pay зэрэг Монголын шилдэг финтекийн шийдлийг ашиглан төлбөр тооцоо хийх боломжийг хэрэглэгчид олгодог бөгөөд хэрэглэгчид финтек ашиглах дадал хэвшлийг суулгахад чухал үүрэг гүйцэтгэж байна.


Энэхүү зорилгын хүрээнд шинээр гарсан төлбөрийн хэрэгслүүдийг сүлжээ дэлгүүрийн төлбөрийн системд амжилттай холбосоор байна. Ингэснээр өдөрт 110,000 гаруй хэрэглэгч өөрийн хэрэглэж заншсан төлбөрийн хэрэгслээрээ төлбөр тооцоогоо саадгүй гүйцэтгэж байна.

Цаашид финтекийн шийдлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний хурдыг улам илүү нэмэх, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах, бэлэн мөнгөтэй холбогдон гардаг зардлыг бууруулахаар олон олон төлбөрийн хэрэгслүүдийг судалсаар байна.



CU APP

2022 оны 5-р сард CU апп шинэчлэгдсэн бөгөөд CU аппын шинэ хувилбарт Купон цэс нэмэгдсэн төдийгүй хэрэглэгч өөрийн CU оноог ашиглан худалдан авалт хийх боломжтой болсон.



ҮНДСЭН СИСТЕМИЙН САЙЖРУУЛАЛТ

GLOBAL IT СИСТЕМ

Компани 2022 онд компанийн алба, хэлтэс, салбар дэлгүүр, түгээлтийн төв болон хоолны үйлдвэр зэрэг дотоод үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, бараа бүтээгдэхүүний урсгалыг хурдтай, оновчтой явуулах, улмаар үйлчлүүлэгчиддээ өгөх конвениенс дэлгүүрийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ компанийн өрсөлдөхүйц шинэ давуу талыг бий болгох зорилгын хүрээнд “Global IT System” нэвтрүүлэлтийн төслийг 1-р сараас эхлэн нийт 9 сарын хугацаанд амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Төслийн хугацаанд компанийн төв оффисын нийт газар, хэлтсүүдийн төлөөллөөс бүрдсэн төслийн баг томилогдон, төслийн гол хамтрагч байгууллагаар CU мастер франчайз эрх олгогч BGF Retail компанийн мэргэжлийн зөвлөх баг хамтран ажиллаж, бид төлөвлөсөн хугацаандаа төсөвтөө багтаан амжилттай хэрэгжүүлж дууслаа. Төслийн хүрээнд төв оффис, дэлгүүр, түгээлтийн төв гэсэн гурван түвшинд нийт 30,000 орчим хүн/цагийг зарцуулсан байна.

Бизнесийн ноу-хау, дата мэдээллийн урсгал, систем хэрэглэгчийн эрх үүргийн зохистой хуваарилалт, дэлгүүрийн ПОС-ын үйлчилгээний сайжруулалт болон олон төрлийн урамшуулал, хөтөлбөрүүдийг системээр дамжуулах боломж зэрэг нь системийн үндсэн давуу тал болж, бидний цаашид хийж хэрэгжүүлэх олон ажлын сайн суурь болж, бид мэдээллийн системийн дэд бүтцээ дахин нэг шатаар ахиуллаа.

Түгээлтийн төвүүдэд нэвтрүүлсэн хагас автомат DPS болон DAS систем нь шинэ хоол болон бусад түргэн мууддаг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэснээс хойш хамгийн бага хугацаанд хэрэглэгчийн гарт хүргэх боломжийг бүрдүүлдэг.

DAS БОЛОН DPS СИСТЕМ

DPS болон DAS системийн нэвтрүүлэлтийн төслийн 2022 оны 12-р сараас эхлэн гурван сарын хугацаанд амжилттай хэрэгжүүлж дууслаа. Төслийн хугацаанд мастер франчайз эрх олгогч BGF Retail Co., Ltd-ий нийт 4 зөвлөх, системийн нийлүүлэгч Asetec компанийн 5 мэргэжилтэн бүхий баг Компанийн ханган нийлүүлэлтийн газар болон мэдээлэл технологийн газартай хамтран ажилласан байна. Системийн давуу тал нь дэлгүүрийн захиалсан барааг түгээлтийн төвийн аль байршлаас, ямар тоо хэмжээтэй бэлтгэхийг гэрлээр дохиолон чиглүүлдэг тул захиалгыг үнэн зөв бэлтгэх боломжийг бүрдүүлж, ажлыг хялбаршуулдаг юм.

CU
URBAN
FEEL

UNIQUE



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН

ОЛОН УЛСЫН ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Дэлхий дахинаа үүсээд байгаа дараах чиг хандлагын үр дүнд конвинеенс дэлгүүрийн жижиглэнгийн худалдааны зах зээлд эзлэх хувь нэмэгдэх төлөвтэй байна.¹

Завгүй амьдралын хэв маяг, өндөр орлого

Уян хатан ажлын цаг, цагийн ажил, олон "жижиг ажил" хийх зэрэг хөдөлмөрийн зах зээлд үүсээд буй чиг хандлага нь хэрэглэгчид гэртээ хэр их цаг зарцуулж буйг тодорхойлоход улам хэцүү болгож байна. Мөн иргэдийн хэрэглээний хандлага өөрчлөгдөж байгаа нь гэрээс гадуурх худалдааг нэмэгдүүлж, өдрийн цагийн гадуур хэрэглээ нэмэгдсээр байна.

Дэлхий даяар ганц бие хүмүүсийн тоо нэмэгдэж, гэрлэлтийн нас улам хойшилж байна. Мөн орон сууцны үнийн өсөлтийн нөлөөгөөр хотжилтын бүсүүдийн орон сууцны хэмжээ жижгэрч, шинээр баригдаж буй барилгуудад хүнсний агуулах боломжтой талбай багассаар байна. Иймд хэрэглэгчид их хэмжээний худалдан авалт хийж хадгалахаас илүүтэйгээр жижиг дэлгүүрээс шууд хэрэглэх худалдан авалтыг илүүд үзэж байна. Мөн хүнсний хог хаягдлыг багасгахын тулд илүү оновчтой, жижиг хэмжээтэй худалдан авалтыг илүүд үзэж байна. Иймд нэг болон хоёр хүнтэй өрхийн тоо нэмэгдэх нь конвинеенсийн хэрэглээг нэмэгдүүлэх хандлагатай байна.

Жижгэрч буй өрхийн хэмжээ

Хотжилт

Дэлхий дахинд суурин хотод амьдарч буй иргэдийн тоо өссөөр байгаа бөгөөд үүний үр дүнд илүү завгүй амьдралын хэв маяг нэмэгдэх хандлагатай байна. Ингэснээр илүү үр ашигтай, цаг хэмнэсэн худалдан авалт илүү чухал болж тухтай хэрэглээг илүүд үзэх хандлага нэмэгдэж байна.

¹Deloitte

**Олон улсын
конвиниенс
дэлгүүрийн
зах зээл**

Конвиниенс дэлгүүрийн зах зээлийн өсөлт нь эдийн засгийн өсөлт, хотжилттой шууд хамааралтай байгаа ба БНХАУ зэрэг хурдацтай хөгжиж буй орнуудад конвиниенс дэлгүүрийн зах зээл өндөр өсөлттэй байна. Харьцангуй тогтворжсон зах зээл болох Япон улсад конвиниенс дэлгүүрийн салбарын орлого жилд дунджаар 2-4 хувиар өсөж, 12.2 их наяд иен буюу 314.15 их наяд төгрөгөөр, Тайван улсад конвиниенс дэлгүүрийн салбарын орлого жилд дунджаар 3-6 хувиар тогтвортой өсөж байна.

Харин зах зээлийн өсөлтийн үе шатаас тогтворжилтын үе шат руу шилжиж буй БНСУ-д 2020 оны байдлаар салбарын орлого 26.5 их наяд вон буюу 60.95 их наяд төгрөгт хүрсэн байна. Тус зах зээлд БНСУ-ын БиЖиЭф Ритэйл (CU brand) болон ЖиЭс Ритэйл (GS Retail, GS25 brand) компаниуд тус бүр 15 мянга орчим салбартайгаар зах зээлд тэргүүлдэг.

	2016	2017	2018	2019	Дундаж
БНСУ	18.4%	14.2%	9.8%	5.2%	11.9%
Индонези	12.5%	11.1%	10.0%	9.1%	10.7%
Тайван	0.0%	2.8%	6.3%	2.8%	3.8%
Япон	4.1%	2.6%	2.0%	1.7%	2.6%

Хүснэгтэд улс орнуудын конвиниенс дэлгүүрүүдийн орлогын өсөлтийг харуулав.

Конвиниенс дэлгүүрийн зах зээл Япон улсад 1970, Тайван улсад 1980, БНСУ-д 1990, Индонези улсад 2010-аад оноос хойш тус тус хөгжин 10-50 жилийн турш оршин тогтнож буй ч өсөлтөө хадгалсаар байна.

Аливаа салбарын амьдралын мөчлөг нь хөгжлийн, өсөлтийн, тогтворжилтын болон уналтын гэсэн дөрвөн үе шаттай байдаг ч конвиниенс дэлгүүрийн салбарт тогтворжих үе шат үргэлжилсээр байгаа нь энэхүү бизнес нь амьдралын урт мөчлөгтэй болохыг харуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДААНЫ ЗАХ ЗЭЭЛ

Худалдааны салбар нь эдийн засгийн нөхцөл байдал, хүн амын худалдан авах чадвараас шууд хамааралтай.


Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийг орлогод болон өрхийн хэрэглээнд суурилсан аргаар эдийн засгийн өсөлтөөс хамааруулан тооцоход 2022 оны байдлаар Улаанбаатар хотын жижиглэн худалдааны зах зээл 18.7 их наяд төгрөгөөр хэмжигдэж, Компани нь 261.0 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь зах зээлийн 1.4 хувийг эзэлж байна.



Конвиниенс дэлгүүрийн зах зээлд эзлэх хувь конвиниенс дэлгүүрийн хувьд хөгжингүй орнуудад жижиглэн худалдааны салбарынхаа 15 хувийг, хөгжиж буй орнуудын хувьд 3 хувийг эзэлдэг. Харин Монгол Улсын хувьд конвиниенс дэлгүүрийн салбар нь жижиглэн худалдааны салбарын 2 орчим хувийг бүрдүүлж байна. Олон улсын жишгээс харвал Монгол Улсад конвиниенс дэлгүүрийн зах зээл өсөх орон зай өндөр байна.

Хүн амын нягтаршилд суурилсан багтаамж

2022 оны эцсийн байдлаар Улаанбаатар хотод нэг конвиниенс дэлгүүрт 3,973 хүн ногдож байна. Бусад Азийн орнуудын жишгээс харахад 2012 оны байдлаар нэг конвиниенс дэлгүүрт дунджаар 2,340 хүн ногдож байсан бол 2018 онд 1,891 болжээ. Энэ нь Улаанбаатар хотод нэг хүнд ногдох конвиниенс дэлгүүрийн тоо олон улсын жишгээр маш бага байгааг харуулж байна.




Улаанбаатар хотын 1.7 сая орчим хүн амыг дээрх үзүүлэлттэй харьцуулан тооцоход 2022 оны эцсийн байдлаар үзвэл зах зээлийн багтаамж 882 дэлгүүр байна.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ТАЙЛАН

Бид бизнесийн үнэ цэн, урт хугацааны амжилтад хөтлөгч гол үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрийг бодитой хэмжих, цаашлаад түүнд суурилсан оновчтой удирдлагын үйл ажиллагааг зохион байгуулахыг зорин ажилладаг.

Тухайлбал, Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн урт хугацааны өсөлт нь дэлгүүрийн дундаж борлуулалтын орлого, дэлгүүрийн тэлэлтийн тооноос шууд хамааралтай бөгөөд харьцуулагдахуйц дэлгүүрийн борлуулалт, нийт сүлжээний борлуулалт, үйл ажиллагааны мөнгөн урсгал зэрэг үзүүлэлтүүд нь бизнесийн өсөлт, үйл ажиллагааны стратегийн үр нөлөөг бодитоор үнэлэх, үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийг тодорхойлоход ашиглагддаг нэн чухал ач холбогдолтой үзүүлэлтүүд байдаг тул Компанийн менежментийн баг эдгээр үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, хэмжиж байдаг.

Иймд Компанийн 2022 оны оны үйл ажиллагааны гүйцэтгэлийг эдгээр чухал үзүүлэлтүүдээр хэмжин энэхүү тайлангаа бэлтгэн хүргэснээр хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад хамгийн чухал мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.






ХАРЬЦУУЛАГДАХУЙЦ ДЭЛГҮҮР

ХАРЬЦУУЛАГДАХУЙЦ ДЭЛГҮҮР гэдэг нь харьцуулагдаж буй хоёр хугацаанд хоёуланд нь үйл ажиллагаа явуулж байсан дэлгүүр юм. Харьцуулагдахуйц дэлгүүрүүдийн тухайн жилийн борлуулалтыг өмнөх хугацааны борлуулалттай харьцуулах замаар бизнесийн гүйцэтгэлийг хэмжих нь чухал ач холбогдолтой. Борлуулалт нь хэрэглэгчдийн тоо болон сагсны дундаж үнээс шалтгаалдаг бөгөөд үүнд дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн тоо, бараа, бүтээгдэхүүний сонголт, мөн сагс дах бүтээгдэхүүний үнэ нөлөөлдөг.

НИЙТ СҮЛЖЭЭНИЙ БОРЛУУЛАЛТ-д Компани эсвэл франчайз эзэмшигчдийн ажиллуулдаг бүх сүлжээ дэлгүүрийн борлуулалтыг авч үздэг. Франчайз дэлгүүрийн борлуулалтын орлого нь Компанийн орлого хүлээн зөвшөөрөлтөд шууд хамаардаггүй ч сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагааны гүйцэтгэл, брэндийн үнэ цэнийг илэрхийлэх чухал үзүүлэлт юм. Франчайз дэлгүүрийн борлуулалт нь франчайз эзэмшигчдийн орлогын үндэс суурь бөгөөд франчайз эзэмшигчийн санхүүгийн тогтвортой байдлыг уг үзүүлэлт тодорхойлдог. Системийн хэмжээний борлуулалтын өөрчлөлт нь нэг дэлгүүрийн дундаж борлуулалт болон дэлгүүрийн тооноос шалтгаалдаг.




НИЙТ СҮЛЖЭЭНИЙ БОРЛУУЛАЛТ




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН УРСГАЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН УРСГАЛ нь Компанийн бизнесийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого, үүнтэй шууд холбоотой гарсан мөнгөн зардал болон эргэлтийн цэвэр хөрөнгөөс хамаарч өөрчлөгддөг.



CU


URBAN
FEEL



VIBE

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛ


Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 2022 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаар 285 дэлгүүртэйгээр 3,400 гаруй ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Компанийн дэлгүүрийн тоо 285 хүрснээс гадна Дархан-Уул аймагт анхны салбараа нээсэн амжилттайгаар бид 2022 оныг үдлээ. 2023 оны 3-р сарын 7-ны өдөр 300 дах салбарын нээлтээ хийж дэлгүүрийн тэлэлт эрчимтэй үргэлжилж байна.



Сая төгрөгөөр	2018	2019	2020	2021	2022
Борлуулалтын орлого	5,687	37,468	45,348	94,038	261,019
Борлуулалтын өртөг	(7,335)	(43,356)	(50,707)	(101,051)	(265,272)
Нийт ашиг/алдагдал	(1,648)	(5,888)	(5,359)	(7,013)	(4,253)
Үйл ажиллагааны зардал	(4,281)	(2,202)	(5,019)	(6,996)	(11,919)
Үйл ажиллагааны ашиг / алдагдал	(5,929)	(8,090)	(10,378)	(14,009)	(16,172)
Санхүүгийн орлого	4	7	159	1,430	1,228
Санхүүгийн өртөг	-	(3,191)	(5,705)	(5,700)	(11,148)
Татварын өмнөх ашиг	(5,925)	(11,274)	(15,924)	(18,280)	(26,092)
Татварын зардал	-	(1)	196	11	407
Татварын дараах ашиг	(5,926)	(11,275)	(15,728)	(18,269)	(25,684)

Компанийн ашигт ажиллагааны маржин харьцаануудын сүүлийн 5 жилийн трендийг харахад өсөх тренд ажиглагдаж байгаа ба 2018 онд нийт ашгийн маржин -29.0 хувь байсан бол 2022 оны байдлаар -1.6 хувь болж сайжирсан байгаа ба хугарлын цэг рүү ойртсоор байна.


Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд



Борлуулалтын орлого, ашигт ажиллагааны үзүүлэлтүүд өмнөх жилүүдээс сайжирсаар байгаа хэдий ч 2022 оны төлөвлөгөөнд хараахан хүрсэнгүй үзүүлэлттэй гарлаа. Компани борлуулалтын орлогын төлөвлөгөөгөө 8.9 хувь давуулсан хэдий ч борлуулалтын өртөг төлөвлөгөөнөөс 13.4 хувь хэтэрснээр нийт ашгийн түвшинд төлөвлөгөөнөөс 12.0 тэрбум төгрөгөөр дутсан байна (нийт ашгийн маржины төлөвлөгөө 5.0 хувь дутсан). Цаашилбал цэвэр ашгийн түвшинд төлөвлөгөөнөөс 13.4 тэрбум төгрөгөөр дутсан нь цэвэр ашгийн маржин 4.7 хувиар дутсан үзүүлэлт юм.

Сая төгрөгөөр	2022 гүйцэтгэл	2022 төлөвлөгөө	Зөрүү
Борлуулалтын орлого	261,019	237,897	8.9%
Борлуулалтын өртөг	-265,272	-229,849	-13.4%
Нийт ашиг/алдагдал	-4,253	8,048	-12,003
Нийт ашгийн маржин	-1.6%	3.4%	-5.0%
Үйл ажиллагааны зардал	-11,919	-9,764	-18.1%
Үйл ажиллагааны ашиг / алдагдал	-16,172	-1,715	-14,436
Үйл ажиллагааны ашгийн маржин	-6.2%	0.7%	-5.5%
Санхүүгийн орлого	1,228	-10,411	-6.6%
Санхүүгийн өртөг	-11,148	-12,126	-13,795
Татварын зардал	407	-	407
Татварын дараах ашиг	-25,684	-12,126	-13,427
Цэвэр ашгийн маржин	-9.8%	-5.1%	-4.7%

Одоо дээрх гүйцэтгэлийн зөрүүнд нөлөөлсөн гол хүчин зүйлсийг авч үзэцгээе.




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Компанийн борлуулалтын орлого өмнө жилээс 178 хувь өсөж 261 тэрбум төгрөгт хүрсэн нь төлөвлөгөөгөө 8.9 хувь давуулсан үзүүлэлт юм. Сүүлийн 4 жилийн үзүүлэлтийг харахад Компанийн борлуулалтын орлого жилд дунджаар 160 хувь өссөн.


Дэлгүүрийн тоо эрчимтэй өсөж байгаа учраас нийт борлуулалтын орлогын өсөлтөөр Компанийн үр ашгийг хэмжих нь зохисгүй тул бид нэг дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалтыг тооцон гүйцэтгэлээ хэмждэг.

Харьцуулагдах дэлгүүр буюу 2020 оны эцэст нээлттэй байсан, 2021 он болон 2022 онд бүтэн үйл ажиллагаа явуулсан нийт 103 дэлгүүр байна. Эдгээр дэлгүүрийн 2021, 2022 оны өдрийн дундаж үзүүлэлтийг харьцуулахад үйлчлүүлэгчийн тоо 60 хувь, худалдан авалтын сагсны дундаж дүн 11 хувь өсөж, өдрийн дундаж борлуулалт 78 хувиар нэмэгдсэн.


Борлуулалтын орлого, сая төгрөг



Уг харьцуулалтыг бүх 285 дэлгүүрийн хувьд хийж үзвэл үйлчлүүлэгчийн тоо 33 хувь, худалдан авалтын сагсны дундаж дүн 10 хувь, өдрийн дундаж борлуулалт 46 хувиар тус тус өссөн байна.



Өдрийн үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн тоо 2021 онд 58 мянга байсан бол 2022 оны 101 мянга болж 1.7 дахин өссөн. Үнэнч хэрэглэгчид болох CU арр хэрэглэгчдийн тоо 598,448 болж 2021 оноос 31 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




2022 онд Компанийн үйлчлүүлэгчдийн худалдан авалтын сагсны дундаж дүн өмнө жилээс 10 хувь өссөн бол Монгол улсын Хүнсний бараа, ундаа, усны хэрэглээний үнийн улсын индекс 17.7 хувь, нэрлэсэн ДНБ 17.6 хувиар тус тус өссөн байна. Өөрөөр хэлбэл макро эдийн засгийн орчин дахь үнийн өсөлтийг хэрэглэгчид рүү шууд дамжуулаагүй гэсэн үг юм.



ӨРТГИЙН ӨСӨЛТ

2021 онд тогтвортой байсан ам.долларын ханш 2022 онд эрс чангарсан. Гадаад валютын ханшийн өсөлт нь импортын бараа, бүтээгдэхүүний өртгийн өсөлтөөр дамжуулан инфляцыг нэмэгдүүлдэг. 2021 оны эцэстэй харьцуулахад ам.долларын ханш 2022 оны эцэст 20.9 хувиар чангарчээ.


Валютын ханшийн хөдөлгөөнөөс гадна чингэлэг тээврийн үнэ 2022 онд өртөгт сөргөөр нөлөөлсөн байна. Хятадын чингэлэг тээврийн индекс болон Хятад Шанхайн чингэлэг тээврийн индексийг харахад 2021 оны эхээс огцом өсөж эхэлсэн харагдаж байна. 2021 оноос өмнөх, индекс тогтвортой байх үетэй харьцуулахад зарим саруудад 450 хувь хүртэл өсөж байв. 2022 оны сүүлийн улирлын байдлаар индекс урт хугацааны дундаж руугаа эргэн тогтворжсон байгаа юм. Чингэлэг тээврийн өсөлт болон гадаад валютын ханшны өсөлт нь барааны өртгийг давхар өсгөсөн байна.



САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 2022 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлэн ажиллаж байна. 2022 онд бид CU сүлжээ дэлгүүрийн тоог 120-р нэмэгдүүлж, 285 дэлгүүртэй болоод байна.

2022 оны эцэст цэвэр борлуулалт 261.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 177.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь төлөвлөгөөг 10 хувь давуулан биелүүлсэн үзүүлэлт болоод байна.




Нийт сүлжээний борлуулалт 293.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 175.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь төлөвлөгөөг 11 хувиар давуулан биелүүлсэн үзүүлэлт болоод байна. Татварын дараах алдагдал 22.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 39.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь төлөвлөгөөнөөс 19 хувь илүү байна. Үйл ажиллагааны ашиг 2.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 148 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Компанийн цэвэр орлого нь 2021 онд 94.0 тэрбум төгрөг байсан бол 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 184.6 тэрбум төгрөг болон 96 хувийн өсөлтийг үзүүлжээ. Татварын дараах алдагдлын хэмжээ 11.6 тэрбум төгрөг болж буурсан байна. Өөрөөр хэлбэл ашгийн маржин хувь -19.2 хувиас 12.9 функтээр сайжирч -6.3 хувь болжээ.


Уг сайжралтад нөлөөлсөн гол хүчин зүйл нь харьцуулагдах дэлгүүрүүдийн гүйцэтгэлийн өсөлт бөгөөд 2022 оноос өмнө нээгдсэн дэлгүүрүүд 2022 оны 2-р улиралд ашигт ажиллагаанд хүрсэн бөгөөд 2022 онд ашигт ажиллагаа 24 хувиар нэмэгдсэн байна.

Компанийн ашигт ажиллагааны маржин харьцаануудын сүүлийн 5 жилийн трендийг харахад өсөх тренд ажиглагдаж байгаа ба 2018 онд нийт ашгийн маржин -29.0 хувь байсан бол 2022 оны байдлаар -1.6 хувь болж сайжирсан байгаа ба хугарлын цэг рүү ойртсоор байна.


Цэвэр орлого (Сая төгрөгөөр)




Татварын дараах ашиг, алдагдал (сая төгрөгөөр)



Нийт хөрөнгө (Сая төгрөгөөр)




Нийт эздийн өмч (Сая төгрөгөөр)



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ томорч буйтай холбоотойгоор ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын менежментийн баг нь учирч болох эрсдэлүүдийг тасралтгүй тодорхойлох, бууруулах, арилгахын тулд богино ба дунд хугацааныарга хэмжээг тогтмолавч, урт хугацааны стратегийн шийдвэр гаргалтуудад гол эрсдэлүүдийг харгалзах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж ирсэн. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн үйл ажиллагаанд учирч болзошгүй голлох 4 эрсдэлийг дараах байдалтай байна.



Жижиглэн худалдааны зах зээл өрсөлдөөн ихтэй тул ойролцоо байршил дах хүнсний дэлгүүр, конвинеенс дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр нэгж дэлгүүрийн болон дундаж борлуулалт буурах, хэрэглэгчдийн тоо хуваагдах эрсдэлтэй. Компани нь зах зээлд давамгайлах стратегийг хэрэгжүүлж, хүн амын хөдөлгөөний урсгал байршлуудад түргэн байршиж, өөр хоорондоо оновчтой зайтайгаар буюу 150-200 метрийн зайд конвинеенс дэлгүүрийг тэлснээр өрсөлдөөнд давуу байдлыг бий болгож, тус эрсдэлийг бууруулна.




Бэлтгэн нийлүүлэгч нь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг захиалгын дагуу гүйцэтгэхгүй байх, тасалдал үүсэх, бэлэн байдал алдагдсанаар борлуулалтын орлого тасалдах эрсдэлтэй. Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь өөрийн нэгдсэн түгээлтийн төвөөр дамжуулан CU конвинеиенс сүлжээ дэлгүүрийн системийн хэмжээний бараа бүтээгдэхүүний удирдлагыг нэгдсэн сувгаар хангаж, бараа бүтээгдэхүүний нөөцийг үүсгэх, тус нөөцөөс дэлгүүр бүрийн захиалгад тулгуурласан тасалдалгүй нийлүүлэлтийг гүйцэтгэх замаар тус эрсдэлийг бууруулдаг.



Монгол улсын эдийн засгийн байдлаас шалтгаалсан олон улсын төлбөр тооцооны гүйлгээний саатал, валютын ханшийн чангаралт, түүхий эд, бараа бүтээгдэхүүний хомсдол зэрэг нь өсөлтийг сааруулж байна. Мөн гадаад хүчин зүйлсээс хамааралтай цахилгаан эрчим хүч, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материалын үнийн өөрчлөлт нь инфляцын түвшинд ихээхэн нөлөөлөл үзүүлж байна. Валютын ханшийн чангаралт, барааны өртгийн өсөлтөөс үүдэлтэйгээр худалдан борлуулах бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсээр байна. Компани нь бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэгч биш учраас үнийг тогтвортой барих боломж хязгаарлагдмал.




Олон улсын франчайз эрх эзэмшиж буйн хувьд үйлчилгээний стандарт алдагдаж брэндийн нэр хүнд унах, харилцагчдын итгэлийг алдах нэр хүндийн эрсдэл үүсэх магадлалтай. Нэр хүндийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Компани нь хэрэглэгчтэй шууд харилцдаг дэлгүүрийн ажилтнуудад QSC үйлчилгээний стандартын сургалтыг тогтмол явуулж, хэрэглэгчийн гомдол, саналыг нээлттэй хүлээн авах, барагдуулах харилцагчийн үйлчилгээний төвийг ажиллуулдаг.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн захиалгаар Антифражайл ХХК нь Компанийн Тогтвортой хөгжлийн тайланг боловсруулсан бөгөөд уг тайланг хураангуйлан Жилийн тайланд дараах байдлаар орууллаа.





URBAN
FEEL

CHILL

МЭНДЧИЛГЭЭ



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ажилчид болон удирдлагын багийг төлөөлөн 2022 оны Байгаль орчин нийгэм засаглал (БОНЗ)-ын тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

Манай Компанийн бизнесийн стратегийн төвд “Хамтын үнэ цэн”-ийн ойлголт хамгийн чухал юм. Энэхүү хамтын үнэ цэн нь бидний бүхий л үйлдэл, шийдвэр гаргалтад нөлөөлдөг суурь зарчим билээ. Бид уг алсын хараанд хөтлөгдсөөр 2022 онд бизнесийн хүрээгээ хурдтай тэлж, илүү олон ажлын байрыг бий болгон, нийлүүлэгчдийнхээ бизнесийг өргөжихөд тусалж, Улаанбаатар хотын иргэдэд эрүүл, аюулгүй, чанартай хоол хүнс, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүллээ.

“Хамтын үнэ цэн”-ийн хүрээнд бид шударга, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаагаа явуулахыг эрмэлзэн компанийн засаглалаа сайжруулсаар байна. Бид хүмүүс, процесс, тогтолцоондоо хөрөнгө оруулж байгууллагын түвшинд ёс зүйг баримтлан ажилласаар байна. Мөн нийгэмдээ хариуцлагатай компани байх нь бидний нэн тэргүүний зорилго юм. 2022 оны онцлох үйл явдлаас дурдвал хоол үйлдвэрлэлийн төвд НАССР (Hazard Analysis Critical Control Point) удирдлагын системийг нэвтрүүлсэн явдал байлаа.

Мөн үүнтэй эн тэнцэхүйц арга хэмжээг хэрэгжүүлсэн нь бид бэлтгэн нийлүүлэгчдэдээ хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоо, ёс зүйг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулсан явдал юм. 2022 онд CU конвиненс сүлжээ дэлгүүрүүд нь шинэ шийдэл, ая тухтай, чанартай үйлчилгээний ахисан стандартыг зах зээлд нэвтрүүлсээр дараагийн жилтэйгээ золгож байна.

Бидний зорилго бол маш энгийн. Монголын хотжиж буй иргэдийн амьдралын чанарыг сайжруулах юм.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд бид харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, ажилчидтайгаа харилцаагаа илүү бэхжүүлж, тогтвортой ирээдүйн төлөөх олон алхмуудыг хийж чадсан. Үүндээ тулгуурлан бид Байгаль орчин, Нийгэм, Засаглал гэх тодотголтойгоор компанийн хөгжилд шинэ хуудсыг эхлүүлэхэд бэлэн боллоо. Бид илүү олон зүйлд хүрч чадна гэдгээ мэдэж байгаа, тэдгээрийг хийж чадна гэдэгтээ ч итгэл дүүрэн байна.

Цаашид бид эрсдэлийн удирдлагын хариуцлагатай туршлагаа үргэлжлүүлж, бизнес хийхэд хамгийн үр ашигтай шийдлийг хайж, үйл ажиллагаандаа тогтвортой, нүүрстөрөгчийн ялгаралт багатай туршлагыг хэрэгжүүлэхээр хүмүүс болон үйл ажиллагаандаа хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөж байна. Бид эх дэлхий, нийгэмдээ эерэг өөрчлөлтийг авчрахаа амлаж байна.

Та бүхнийг тогтвортой хөгжлийн төлөөх бидний хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд нэгдэхийг уриалж байгаадаа таатай байна. Бид хамтдаа байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлж, "Хамтын үнэ цэн"- ээ нэмэгдүүлж чадна.

Үргэлж дэмждэг та бүхэндээ чин сэтгэлээсээ талархаж байна.



Гари Стивен Биондо


Төлөөлөн удирдах зөвлөлийн БОНЗ хорооны дарга

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2-р сарын 25-ны өдрийн 7 тоот тогтоолоор ("ТУЗ")-ийн дэргэдэх Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо ("БОНЗ-ын хороо")-ны үйл ажиллагааны журмыг баталсан бөгөөд БОНЗ-ын хорооны үйл ажиллагааны чиглэл, эрх үүргийн дагуу БОНЗ-ын чиглэлд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар ТУЗ-д жилд хоёроос доошгүй удаа тайлагнах үүрэг хүлээдэг.

ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 оны байдлаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ажилтнуудад нийт 136,674 хүн цагийн сургалт орсон бөгөөд ажилтнуудын сургалт хөгжилд нийт 535.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Салбарын онцлогоос шалтгаалан ажилтны шилжилт хөдөлгөөн өндөр байдаг тул шинээр ажилд орсон ажилтанд байгууллагын соёлыг танилцуулах, харилцаа үйлчилгээний соёлыг хэвшүүлэх, эрүүл ахуйн зөв дадалтай болгох чиглэлд тогтмол сургалтуудыг ордог.



Нийт сургалт хөгжил, хүн цаг



БАЙГАЛЬ ОРЧИН

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК болон Сэнтрал Фүүдс ХХК нь өөрийн оффисоос гадна 285 конвинеиенс салбар дэлгүүр, нэг хоолны үйлдвэр, түүний дэргэдэх хүйтэн хэлхээт түгээлтийн төв, мөн хэвийн температурын горимтой бүтээгдэхүүн түгээлтийн төв гэсэн объектуудад үйл ажиллагаа явуулдаг.

ЭРЧИМ ХҮЧ

2021 онтой харьцуулахад 2022 оны цахилгааны хэрэглээ 60 хувиар нэмэгдсэн нь дэлгүүрийн тоо нэмэгдсэнтэй холбоотой. Нийт цахилгааны хэрэглээний 86.3 хувийг сүлжээ дэлгүүрүүд, 13.5 хувийг хоолны үйлдвэр, 0.1 хувийг оффис, 0.1 хүрэхгүй хувийг хэвийн горимт түгээлтийн төв эзэлж байна.


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭР ХЭРЭГЛЭГЧЭЭР, кВт.ц /2023/



ЭРЧИМШИЛ

Нийт эрчим хүчний хэрэглээний 86.3 хувийг салбар дэлгүүрүүд эзэлж байгаа бөгөөд эрчимшлийг тооцож үзвэл дэлгүүрт 1 хэрэглэгчид үйлчлэхэд 43.93 кВт.ц ашигладаг, 1,000,000 төгрөгийн борлуулалт бүрд 512.75 кВт.ц ашигладаг. Энэ нь 2019 онтой харьцуулахад 1 хэрэглэгчид үйлчлэхэд ашигладаг байсан эрчим хүчний хэмжээ 2 дахин, 1 сая төгрөгийн борлуулалт хийхэд зарцуулдаг эрчим хүч 5 дахин тус тус буурсан үзүүлэлт буюу компанийн үр ашиг нэмэгдэж, эрчим хүчний зарцуулалтын үр ашиг мөн нэмэгдэж байгааг харуулж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРЧИМШИЛ, КВТ.Ц



Сэнтрал экспресс Си Ви Эс ХК нь түгээлтээ гэрээт компаниар хийлгэдэг бөгөөд УБ хотын хөл хөдөлгөөн хамгийн багатай шөнийн цагаар бүх түгээлтийг хийдэг

ТҮЛШ БАГА ЗАРЦУУЛДАГ, АГААРЫН БОХИРДОЛ БАГАТАЙ ТЭЭВЭР

Мөн энэ онд хүйтэн хэлхээний түгээлтийн дэд бүтцийг байгуулсан ба улмаар 400 гаруй үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчдийн бүтээгдэхүүний түгээлтийг төвлөрүүлэн, 6 сая орчим зорчих хөдөлгөөнийг 132 мянга болтол бууруулж нийслэл хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулахад хувь нэмрээ орууллаа.

Ингэснээр энгийн үетэй харьцуулахад агаарын бохирдлыг 98 хувиар бууруулж буй арга хэмжээг нэвтрүүлэхэд зарцуулсан 15 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт болжээ.

Түгжрэлгүй үед түгээлт хийснээр 4 дахин цаг хэмнэхээс гадна шатахуун зарцуулалтыг 80 хувиар бууруулдаг (Трэйбэр эт ал, 2007). Илүү бага дизель зарцуулахаас гадна түгжрэлд удаан зогсохгүй, тогтмол хурдаар явж байгаа учир хэмнэсэн хугацааны турш ялгарах байсан дизелийн утаанаас сэргийлж агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг тэр хэрээр бууруулж байна.

Түүнчлэн түгээлтийн төвд тээврийн смарт систем хэрэгжиж эхэлснээр нийт зарцуулсан бензин, туулсан зам гэх мэт олон төрлийн мэдээллийг бүртгэж, тооцоолох боломжтой болгохоор ажиллаж байна.




ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2021 оноос эхлэн дэлгүүрүүд ачаалал багатай цагууддаа буюу байршлаас хамааран дунджаар шөнийн 2-5 цагуудын хооронд ашиглагдахгүй тоног төхөөрөмжүүдийг унтраах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд салбар дэлгүүрийн хоол боловсруулах хэсгийн төхөөрөмжүүд багтана.

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг өдөр тутам, тогтмол хяналт хийж хэвийн, үр ашигтай үйл ажиллагааг ханган ажиллаж байгаа нь зориулалтаас илүү их цахилгаан зарцуулахгүй, үр ашигтай байдлыг хангаж байна.



Түгээлтийн төв нь нартай үед өдрийн цагаар талбайн гэрэлтүүлгийн унтрааж байгалийн гэрлийг ашигласнаар 4,200 м² бүхий талбайг гэрэлтүүлэх эрчим хүчийг хэмнэж байна.

Дэлгүүр, үйлдвэрлэлийн гэрлүүд нь тодорхой стандартыг барьдаг бөгөөд эрчим хүчний үр ашигтай ЛЭД гэрэлтүүлэгтэй.



УС ХЭМНЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


УСАН ХАНГАМЖ

Хоолны үйлдвэрт ашиглагдах ус 4 төрлийн мембран фильтрээр физик, хими, микробиологийн цэвэршүүлэлт хийгдэн ашиглагддаг, фильтрийг жилдээ нэг сольдог. Усны чанарыг Эрүүл ахуйн журмын дагуу улирал бүр холбогдох байгууллагаар шинжилгээнд хамруулж, үйлдвэрээс гарах хаягдал ус бохирын төвлөрсөн шугамд нийлүүлэгддэг.

Конвиниенс дэлгүүрүүдийн хувьд цэвэр усны хэрэглээ нь халуун цай болон бусад найруулдаг уух зүйлс бэлтгэх, цэвэрлэгээ хийх, болон ариун цэврийн өрөөний хэрэглээнээс бүрдэнэ.

Хоолны үйлдвэрийн усны хэрэглээ нь хоол үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, ахуйн хэрэглээ, лабораторийн цэвэрлэгээ гэсэн гол зориулалтаар хэрэглэнэ.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ, Л



Дэлгүүрүүд цэвэрлэгээгээ ээлж солигдоход буюу ажлын цагийн хуваариас хамааран 2-3 удаа цэвэрлэдэг бөгөөд эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан цэвэрлэгээний бодисыг стандарт ажиллагааны зааврын дагуу ашигладаг. Үйлдвэрийн хувьд өдөртөө нэг тогтмол цэвэрлэгээг хийдэг бөгөөд мэргэжлийн цэвэрлэгээний байгууллагаар улиралдаа нэг их цэвэрлэгээ хийлгэдэг.



Мэдрэгчтэй угаалтуурын тоог 8-р нэмж, 20 суултуурын усны таталтыг 50 хувиар бууруулсан.

ХОГ ХАЯГДАЛ

Бүх объектууд харьяа дүүргийн холбогдох тохижилт үйлчилгээний төрийн компаниудтай гэрээлсэн бөгөөд зарим СУ дэлгүүрүүдийн хувьд түрээслэгч хаягдлыг хариуцдаг.

Эх үүсвэр	Үйл ажиллагаа	Ялгарах хог хаягдлын төрөл
Дэлгүүр	Бүх төрлийн бараа бүтээгдэхүүн зарж борлуулах	Сав, баглаа, боодол: хуванцар, гялгар, цаас
	Хоол бэлтгэл, хоол зарж борлуулах	Хүнсний шингэн, хатуу хаягдал (органик), нэг удаагийн хуванцар хэрэгслүүд, салфетка
	Кассын баримт гаргах	Кассын баримтын цаас
	Хугацаа дууссан/Чанарын доголдолтой бараа актлах	Хүнсний шингэн, хатуу хаягдал (органик), сав, баглаа боодол
	Ариун цэвэр, ахуйн хаягдал	Ариун цэврийн хэрэглэлүүд
	Бичиг хэрэг	Цаас
Үйлдвэр, хүйтэн хэлхээт түгээлтийн төв	Хоолны үйлдвэрлэл	Ногооны хальс, хаягдал тос, түүхий эдийн хайрцаг, сав баглаа боодол, шуудай, төмөр лаазны хаягдал, үйлдвэрлэлийн үед чанарын доголдолтой, стандартад нийцээгүй учир акталсан хүнсний хаягдал,
	Лабораторийн шинжилгээ	Хоолны дээж, лабораторийн урвалж, бодисын хаягдал
	Эрүүл ахуйг хангах	Маск, бээлий гэх мэт эрүүл ахуйн чиглэлийн нэг удаагийн хэрэглэлүүд, хагас жилд 1 солигддог үйлдвэрийн ажилчдын хувцас,
	Галлагаа	Үнс
	Ариун цэвэр, ахуйн хаягдал	Ариун цэврийн хэрэглэлүүд
	Бичиг хэрэг	Цаас
Хэвийн горимт түгээлтийн төв	Агуулахын бөөний барааг жижиглэнгээр дэлгүүрийн хэрэгцээнд бэлтгэх	Олон төрлийн ундааны баглаа гялгар, бусад картон, цаасан сав баглаа боодол
	Ариун цэвэр, ахуйн хаягдал	Ариун цэвэр, ахуйн хаягдал
	Бичиг хэрэг	Цаас

САЛБАР ДЭЛГҮҮР

CU конвинеенс дэлгүүр нь дэлхийд хог хаягдал ангилан ялгалт, дахин боловсруулалтаараа тэргүүлэх орнуудын нэг БНСУ-аас эхтэй, тухайн систем, дэд бүтцэд тулгуурлан хөгжүүлсэн импортын бараа бүтээгдэхүүнүүдийг оруулж ирдэг. Тус дэлгүүрийн хамгийн өндөр борлуулалттай бүтээгдэхүүн болох кофены аяга болон таг нь байгальд 95 хувь уусдаг материалаар хийгдсэн байдаг бөгөөд улмаар компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 372 мянга тонн хуванцар хог хаягдлын бохирдлоос сэргийлээд байна.

Түгээлтийн төв нь картон хайрцгийг хаягдал болголгүй дахин ашигладаг сайн туршлагатай. Мөн захиалга бэлтгэх хагас автомат системийг нэвтрүүлж эхэлсэн. Ингэснээр цаасны хэрэглээг 2 дахин багасгаж өдөрт дунджаар 3 мянга ширхэг буюу 1.8 кг, жилдээ 630 кг бичгийн цаасны хэрэглээг багасгах боломж бий болж байна.

ТҮГЭЭЛТИЙН ТӨВ

ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

2021 онд Өнгө Нэм ТББ-аас компанийн захиалгаар гаргасан Хог хаягдлын менежментийг сайжруулах зөвлөмжийн дагуу хогийн савыг үйлдвэр болон оффисын орчинд тодорхой байршилд байрлуулж, ариутгалын бүртгэлтэй болж, дахин боловсруулах боломж, хамтын ажиллагааг судлан ажиллаж байна.

Компани нь хамтран ажилладаг ханган нийлүүлэгчидтэй хийх мастер гэрээндээ "ажлыг гүйцэтгэхтэй холбогдон гарсан аливаа хог хаягдлыг заасан цэгт хаяж, өөрийн хүчээр зайлуулж цэвэрлэх, мөн гэрээлэгч нийтийн талбайд ямар нэгэн хаягдал үүсгэхгүй, бохирдуулахгүй, үүссэн хаягдал, бохирдлыг бүрэн цэвэрлэж, орчны хэвийн нөхцөлийг тухайн ажлын өдөрт нь сэргээж, цэвэрлэх шаардлагыг тавьдаг.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИД

“

GP батарей компанитай хамтран **100кг** батарейны хаягдлыг цуглуулж, тушаасан

“

Аягагүй кофе” хөтөлбөрийн хүрээнд **83,307** үйлчлүүлэгчид нийт **90,415** ширхэг аяганы хог хаягдал үүсэхээс сэргийлжээ

“

Хагас автоматжсан захиалгын системийг нэвтрүүлснээр жилд дор хаяж **630 кг** хаягдал цаас булагдахаас сэргийлэх төлөвлөгөөтэй.

“

Хаягдал тосыг савангийн үйлдвэрт нийлүүлэхээр ярилцаж байна.


ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН САЙН ЖИШЭЭ

Сэндвичийн савлагааг **МАР технологи** буюу савалгаан дах агаарын горимыг өөрчлөн тохируулснаар бактери, микро-организм үржих боломжгүй, исэлдэхгүй орчныг үүсгэж, хадгалах хугацааг уртасгадаг.

ХҮНСНИЙ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ САВЛАГА

Ингэснээр эрүүл, чанартай хүнсийг илүү урт хугацаанд хадгалж, хэрэглэгчдэд хүрч амжилгүй актлагдах хүнсний хаягдал үүсэхээс сэргийлж байна.

Хоол хүнс хаягдахдаа агаар мандалд дулаанаа барих чадвар өндөртэй хүлэмжийн хий болох метаныг ялгаруулж байдаг учир хүнсний хаягдал гаргахгүй байх нь уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлж буй маш том хувь нэмэр юм. Үүнийг олон улсын зорилтуудад мөн тусгасан байдаг. Жишээ нь, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 12-н хүрээнд 2030 он гэхэд нийт хаягдаж буй хүнсний хог хаягдлыг 50 хувиар бууруулах зорилт тавьсан.




НИЙГЭМ

CU брэнд салбар дэлгүүрийн тоогоо нэмэгдүүлэхийн хэрээр шинэ ажлын байрыг ихээр бий болгож 2022 оны эцсийн байдлаар өмнөх онтой харьцуулахад 3,200 хүнийг шинээр ажлын байртай болгожээ.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ


Монгол Улсад “цагийн ажил” гэх ойлголтыг нутагшуулж, өдгөө ажилтнуудын 52 хувийг цагийн ажилтнууд буюу дийлэнхийг оюутан залуус эзэлж байна. Оюутан залууст хичээлийнхээ хажуугаар тогтмол орлоготой, уян хатан цагийн хуваарийн дагуу өөрт ойр байршлаас ажиллах боломжийг олгодог давуу талтай.




Сүүлийн 12 сард менежер ба түүнээс дээш албан тушаалд дэвшсэн байдлыг хүйсээр ангилан харвал нийт албан тушаал дэвшсэн байдал эмэгтэйчүүд 52 хувийг эзэлж байна.

Харин сүүлийн 12 сард ажлаас чөлөөлөгдсөн байдлыг харвал нийт ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудад эмэгтэйчүүд 62.6 хувийг эзлэх бөгөөд сүүлийн 12 сард шинээр 1,852 хүн ажилд авснаас үүний 60.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.


Тушаал дэвшилт, хүйсээр



Ажлаас чөлөөлөгдсөн байдал, хүйсээр



Шинээр ажилд авсан байдал



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

ХАБЭА-Н УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Компани нийт ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор ХАБЭА-н бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг. Тус бодлогын хүрээнд өглөө бүр дэлгүүр, үйлдвэр, түгээлтийн төвүүдэд товч хурал болдог ба өмнөх ээлжийн мэдээлэл, стандарт ажиллагааны зааварчилгаа, ХАБЭА-н зааварчилгааг өгдөг.

Үйлдвэр, түгээлтийн төвийн ажилчид өглөө бүр ХАБЭА-н зааварчилгааг сонссон бүртгэлд гарын үсэг зурдаг. Дэлгүүрийн хувьд ээлж солигдох бүрд Нэгдсэн бүртгэлийн дэвтэрт өмнөх ээлжийн мэдээллийг багтаан, ээлжийн ахлах зааварчилгааг бичгээр болон аман байдлаар өгдөг.



Нийт 3,000 хүнийг тогтмол эрүүл ахуйн шаардлагын дагуу халдварт өвчний шинжилгээнд хамруулдаг ба холбогдох нэгж, ажилчдад дараах шинжилгээнүүдийг зохион байгуулсан. Үүнд эрүүл мэндийн хугацаат үзлэг 80, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 391, хеликобактерийн тест 68, дүүргийн эрт илрүүлгийн шинжилгээнд 24 ажилчин хамруулсан.

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ


Дэлгүүр бүр галын аюулгүй байдлыг хангах зорилгоор 2 гал унтраагуур, галын хөнжил, угаарын хий мэдрэгч сенсороор тоноглогдсон байх ба тэдгээрийн хугацааг тогтмол хяналтын хуудас хөтөлдөг байна.

Хүнсний үйлдвэр нь 100 хувь автомат гал хамгааллын системтэй. Мөн газын байгууламж мэдрэгч сенсортой учир газ алдагдах тохиолдолд автоматаар хэрэглээг зогсоох, унтрах тохиргоотой.

ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн нийт ажилтнууд ба дунд ба анхан шатны нэгжийн ажилтнуудад эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна. Харин ТУЗ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 0 хувь, Гүйцэтгэх удирдлагын багт эмэгтэйчүүд 73 хувийг эзэлж байна. Жендерт суурилсан цалин хөлсний зөрүүг харвал эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.14 дахин өндөр цалин хөлс авч байна.

Ажилтнуудын хүйсийн харьцаа, албан тушаалаар



Цалин урамшуулал, хүйсээр



ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ


ХҮНИЙ НӨӨЦИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Компани нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин үүсгэн байгуулагдсан үеэс хойш СИ дэлгүүрүүдэд ажлын байрыг хуулийн квотын дагуу биелүүлсээр ирсэн.

Ханган нийлүүлэгч үйлдвэрүүд ч үүнийг үлгэрлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангадаг жишиг тогтжээ

2022 оны хувьд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн нийт ажилчдын 4.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байсан байна. Дэлгүүрүүдэд саажилттай, сонсголын бэрхшээлтэй зэрэг хүмүүс ажиллах нь элбэг. Зарим хүнсний үйлдвэрүүдэд тэргэнцэртэй хүмүүс ч ажиллах боломжтой, ажиллаж байсан түүх бий. Тухайн хүний бэрхшээлээс хамааран цэвэрлэгчээс гадна касс бичилт, бараа өрөлт, тооллого, хоол бэлтгэлийн хэсэгт ажиллах гээд олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг.

ХБИ АЖИЛТАНД БИЙ БОЛГОСОН АЖЛЫН БАЙР, ХҮН ЦАГААР



Үүнээс гадна хүнсний үйлдвэрийн ажилтнуудын хувьд Хонхорт байрлах учир хүний нөөцийнхөө 50 хувиас дээш хувийг ойролцоох Налайх дүүргээс бүрдүүлсэн бөгөөд үүний тал орчим нь Казах иргэд байдаг. Монгол хэлээр ярьдаггүй ажилчдын тохиолдолд Монгол хэлтэй Казах ажилчинтай бадди системээр ажиллуулдаг бөгөөд Казах уламжлалт тэмдэглэлт баяр, зан заншлыг хүндэтгэн авч үздэг.


ХОТ СУУРИН ГАЗРЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

CU дэлгүүрээр үйлчлүүлж буй сая хүн дараах үйлчилгээг ямар нэг худалдан авалт хийх нөхцөлгүйгээр санал болгож, нийслэл болон салбар дэлгүүр байршиж буй бүс нутгийн хоол үйлчилгээний соёл, стандартын хөгжилд хувь нэмрээ оруулж эхлээд 4 жил болжээ.



Нийт салбар дэлгүүрүүдийн 91 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөө, гаругаах тосгуураар тоноглогдсон байдаг нь Нийслэл хотын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

CU дэлгүүрүүд гадаад орчны 50м талбайгаа тохижуулсан гэрэлтүүлэгтэй, халтиргаа гулгаанаас хамгаалж цэвэрлэдэг.



1 сарын хугацаатай хадгалагддаг камерын бичлэг хийгддэг бөгөөд хүмүүс юмаа мартаж орхих, хулгай, гэмт хэрэгт өртөх гэх мэт тохиолдлуудад холбогдох байгууллагын зөвшөөрлөөр бичлэг шүүж авах боломжтой.

Хотын төв, захын бүсүүдэд кофе шоптой адил үйлчилгээ үзүүлэн тав тухыг мэдрүүлдэг.



Шуудангийн үйлчилгээ



Stora хүргэлтийн цэгүүд тодорхой цэгүүдэд байрласан. Мөн төрийн үйлчилгээний киоск цэгүүдийг байрлуулахаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Ковид-19 цартахлын үед хүргэлтийн үйлчилгээг хэрэгжүүлж байсан нь өндөрлөсөн бөгөөд цартахлын үед ч мөн зогсолтгүй хэрэглэгчдэдээ ойр байх зарчмыг баримтлан хэрэглэгчид хамгийн ойрын салбараасаа хамгийн хурднаар хүргэлтийг авах боломжтой байснаараа онцлог.

Хүргэлтийн үйлчилгээ



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ

Компани нь оролцогч талууд, коммюнити-тэй ажиллах тусгайлсан бодлого, журам батлаагүй хэдий ч компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд аль хэдийн оролцогч талуудын хамтарсан оролцоог хангасан ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Улмаар улс орны иргэдийн амьдралыг чанарыг дээшлүүлэх, иргэдийн дунд нэгнээ хүндэтгэн харилцах соёлыг түгээх зэрэг нийгэм соёлын шинжтэй санаачилгуудыг НЗДТГ, НЦУГ болон Орон нутгийн ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлдэг.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

МУ-ын нийгэм, эдийн засаг, жижиг дунд худалдаа үйлчилгээ эрхлэх салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох, хотын соёлыг хөгжүүлэх, худалдаа үйлчилгээний салбарын хөгжлийн өнөө ба ирээдүй үеийн хэрэгцээ шаардлагыг хангаж ажиллах зорилгын дор хамтын ажиллагааны санамж бичгийг 2022 оны 10-р сарын 13-ны өдөр байгуулсан.

Талууд нь дараах чиглэлд хамран ажиллаж байна. Үүнд



Нийслэлийн хүн амыг эрүүл хүнсээр хангах



Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх



Ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих



Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх



Байгаль орчин, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих



Гарааны бизнесийг дэмжих

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дархан сумын иргэдэд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах, бизнес эрхлэгчдийн шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх, зорилтот бүлгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, “Ногоон Дархан” хөтөлбөрт хамтран ажиллах санамж бичгийг 2022 оны 11-р сарын 24-ний өдөр байгуулан ажиллаж байна.

“СУ ЧАМД ТУСАЛЪЯ” ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР



Нийслэлийн цагдаагийн ерөнхий газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран хэрэгжүүлж байгаа “СУ ЧАМД ТУСАЛЪЯ” хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хүрээнд эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрч, тусламж эрсэн 7 хүүхдийг цагдаагийн байгууллагаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчид нь аюулгүй хүлээлгэн өгсөн.

Уг төслийн зорилго нь бага насны хүүхдийг төөрөхөөс сэргийлэх, төөрсөн хүүхдийг аюулгүй байлгах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх бөгөөд СУ брэнд Улаанбаатар хот дах 285 гаруй салбар дэлгүүрээр дамжуулан тусламж үзүүлэх, дэлгүүрийн дотоод мэдээллийн сүлжээгээр дамжуулан бүх салбарт төөрсөн хүүхдийн мэдээллийг хүргэх, харьяа дүүргийн цагдаагийн газартай шуурхай холбогдож мэдээллийг хүргүүлэн, хүүхдийг гэр бүлд нь аюулгүй хүлээлгэн өгөхөд оршиж байна.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн нийт худалдан авалтын 91 хувь, Сэнтрал Фүүдс компанийн 90 хувь нь дотоодын ханган нийлүүлэгчид эзэлж байгаа. Ингэснээр дотооддоо 53.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн урсгалыг бий болгосон бөгөөд шууд бус буюу ханган нийлүүлэгчдийн төлсөн татвар ойролцоогоор 5 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлээд байна.

ТОГТВОРТОЙ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ

Ханган нийлүүлэгчдийн нөөцийн удирдлага, үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарыг сайжруулах зорилгоор “Хамтдаа хөгжье” 2 шаттай хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт 12 үйлдвэрийг хамрууллаа.

ХАМТДАА ХӨГЖЬЕ: ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

СУ дэлгүүр нь нийт 17 хоол үйлдвэрлэгч Монгол бизнестэй хамтран ажилладаг бөгөөд түүнээс эхний ээлжид 12 үйлдвэрийг сонгон дараах 2 шаттай сургалтыг орсон. Үүнд:



Сургалтын үр дүнд зохистой дадлын сургалтыг үйлдвэрийн дарга, техникчийн түвшинд авсан, бичиг баримтын бүрдлийг сайжруулсан, дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн, ажилчдын эрүүл ахуй, ариун цэврийн дадал сайжирсан, үйлдвэрийн давхцалыг арилгасан, үйлдвэрийн байрыг сайжруулсан, ажилчдын идэвх чармайлт нэмэгдсэн гэх мэт маш олон төрлийн үзүүлэлтээр ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаа сайжирсан байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт бодитой эерэг хувь нэмэр оруулж, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэл найдварыг өндөрт хадгалж, салбартаа манлайлж ажиллахыг зорьж байна.

Энэ хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилтын 9 зорилгод дараах байдлаар хувь нэмрээ оруулж байна (2023 оны 2-р сарын байдлаар).

ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь байгуулагдсан цагаасаа өрхийн гишүүн бүр ажиллах боломжтой, уян хатан цагийн хуваарь бүхий ажлын байруудыг бий болгож, улмаар орлогын шинэ эх үүсвэртэй болох боломжийг бүх иргэдэд нээлттэй санал болгосоор байгаа.

Өрхийн гишүүн бүр орлогын эх үүсвэртэй болох нь ядуурлыг бууруулахад маш чухал үр дүнтэй юм.



ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ



Нийт 12,461,391 шинэхэн, эрүүл, аюулгүй хоолыг үйлдвэрлэн нийлүүлсэн.

Түүхий эдээс хэрэглэгчийн гарт хүртэл нийлүүлэлтийн гинжин хэлхээг 100 хувь хянаж байгаа.

ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Хүйсийн эрх тэгш байдал, нийгмийн тэгш оролцоог хангах чиглэлд онцгой анхаарал хандуулан ажилладаг.


Компанийн төв оффис, түгээлтийн төв, хоолны үйлдвэр болон 300 гаруй салбар дэлгүүрт ажилладаг 3,400 гаруй ажилтан, менежерүүдийн 67 хувийг эмэгтэй ажилтнууд бүрдүүлж байна.



БАТАЛГААТ УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ




Ая тухтай үйлчилгээ үзүүлэх зорилгынхоо хүрээнд СУ сүлжээ дэлгүүрүүдийн 91 хувь нь чанарын шаардлага хангасан ариун цэврийн өрөө, гар угаах тосгуураар тоноглогдсон байдаг бөгөөд үйлчлүүлэгчдэдээ үнэ төлбөргүй үйлчилж байна.



ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ



СУ сүлжээ дэлгүүрүүд оффис, эмнэлэг, зам дагуу зэрэг хүнсний худалдаа төдийлөн байршдаггүй, хүн амын суурьшлын бус шинэ байршлуудад нийт 201 салбар нээж хүний өдөр тутмын хэрэгцээг хангах дэлгүүр, үйлчилгээг бий болгож байна. Нийт 122,516,898 бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн гарт хүргэсэн.



ИННОВАЦ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



Бид үйлчлүүлэгчдэдээ шинэхэн, эрүүл, аюулгүй хоолыг хүргэх зорилгоор найдвартай хүнсний гинжин хэлхээ, хоол нийлүүлэлтийн сүлжээг бий болгож, салбар бүрд шинэхэн хүнсний хүргэлтийг өдөр бүр хийдэг.

Энэхүү дэд бүтцийн тусламжтай дэлгүүрийн өдөр бүрийн хэрэгцээт 2,000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг ердөө 2 хүргэлтээр шийдэж, хотын авто замын хөдөлгөөний ачааллыг буурууллаа.

- Найдвартай хүнсний гинжин хэлхээ, түгээлтийн сүлжээг бий болгож, 6,600,000 удаагийн тээврийг 132,000 болгож бууруулан хотын замын ачааллыг бууруулсан.
- Агуулахын бараа ангилалт, ялгалтын DAS/DPS шийдлийг Монголд анх удаа нэвтрүүлж 99 хувийн оновчлолтой захиалгын системийг бий болгосон.
- CU апп-ын татан авалт 600,000 орчим үүнээс сар бүр идэвхтэй хэрэглэгчдийн тоо 116,000

ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн харилцаанд оролцох тэгш боломжийг бий болгож, найдвартай ажлын байраар хангах нь өөртөө итгэх итгэл, амьдралын идэвхийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Тийм ч учраас бид ХБИ иргэдэд тэгш боломжийг санал болгож, нийт 421,000 хүн цагийн ажлын байр бий болгоод байна.



ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ



Бид бүх салбар дэлгүүрээр зочилж буй үйлчлүүлэгч бүрийг хүндэтгэн мэндчилж, тэдэнд чин сэтгэлийг найрсаг үйлчилгээг үзүүлэхийг хичээдэг. Энэхүү хичээл зүтгэл маань үйлчлүүлэгч бүрд хотын амьдралын стрессээс ангижирч, шинэ эрч хүчээр өөрийгөө цэнэглэн, улмаар бусдадаа эерэг энерги, эрч хүчийг түгээнэ гэдэгт бид чин сэтгэлээсээ итгэдэг. Тийм ч учраас бид бүх ажилтнууддаа харилцаа, үйлчилгээний соёлын сургалтыг тогтмол явуулдаг бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 224,115 хүн цагийн сургалтыг орж, найрсаг харилцааны дадал зуршлыг ажилтнууддаа хэвшүүлэн ажиллаж байна.

CU сүлжээ дэлгүүр нь хурдацтай, далайцтай тэлж Улаанбаатар хотын гудамж талбайд аюулгүй, гэрэлтэй, харуул хамгаалалттай, гадна, доторхоо бүрэн камержуулсан орчныг бүрдүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд бодитой хувь нэмэр оруулж байна. Мөн хүүхэд багачуудыг аюул ослоос хамгаалах, төөрсөн хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх зорилготой "СИ ЮУ ЧАМД ТУСАЛЪЯ" төслийг Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газартай хамтран хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр нь зөвхөн төөрсөн хүүхдүүдийг хамгаалаад зогсохгүй, гэр бүлийн хүчирхийллээс үүдсэн аюултай нөхцөл байдлын үед хүүхдүүдэд түр орогнох байр болж, аюул өнгөртөл хамгаалах орчныг бүрдүүлж өгдөг.

- Хүн цагийн сургалт: 224,115 хүн цагийн сургалт.
- Дотор болон гадна орчны камерын хяналт
- Харуул хамгаалалтын шуурхай үйлчилгээ
- Төөрсөн 7 хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн.

ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ



Бид үйлчлүүлэгчдэдээ үргэлж ариун цэврийн шаардлага хангасан, шинэ туслах хэрэгсэл, хайрцаг савтай бүтээгдэхүүнээр үйлчилдэг. Улмаар эдгээр туслах хэрэгслийн хаягдал нь байгальд орчинд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор бид түргэн устдаг хуванцар таг, Дэлхийн ойг хамгаалах Rainforest Alliance сертификат бүхий аягыг хамгийн олноор борлуулагддаг кофендоо ашиглаж байна. Мөн Аягагүй кофе хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 90,415 ширхэг кофены аяга хаягдахаас сэргийлж чадлаа.

Кофены аяга болон таг нь 95 хувь байгальд уусдаг бөгөөд улмаар бид 372,000 кг хаягдал байгалийг бохирдуулахаас сэргийлээд байна.

ЗАСАГЛАЛ



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн засаглалын бүтэц нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн, үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг.

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон олон улсад танигдсан шилдэг туршлага, зарчмуудыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах, бизнесийн ёс зүй, ил тод, шударга байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох албан ёсны зөвшөөрлөө 2021 оны 10-р сарын 13-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос ("СЗХ") авсан бөгөөд 2021 оны 11-р сарын 03-ны өдөр Монголын хөрөнгийн бирж ТӨХК ("МХБ")-ийн III дугаар ангиллаар нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч арилжаагаа амжилттай дуусгаж, 2021 оны 11-р сарын 12-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаагаа нээснээр нээлттэй хувьцаат компани болсон.

2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны тоо 817,768,643, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 10,108 байгаа бөгөөд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.



КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хууль болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-өөс баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам болон Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4-р сарын 23-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхрын хурлын танхимд амжилттай зохион байгуулсан бөгөөд тус хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.38 хувь нь оролцож дараах үндсэн 5 асуудлыг танилцуулсан.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хангах үүднээс Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг олоннийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах, <https://hural.cumongol.mn> веб хаягаар хуралд бүртгүүлэх, урьдчилан санал өгөх боломжоор хангасан. Мөнтүс хуралд ТУЗ-ийн бүх гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон Компанийн хөндлөнгийн аудитор байгууллагын төлөөлөгчид оролцож дээрх асуудлуудтай холбогдох хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт, тодруулга өгсөн.


ХУВЬЦААНЫ ГҮЙЦЭТГЭЛ



МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 20 дугаар зүйлийн 20.2, 20.3 дах заалтууд болон Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн 2022 оны 4-р сарын 26-ны өдрийн 151242-16/22-304 тоот албан бичгээр хүргүүлсэн ангилал ахиулах тухай хүсэлтийг үндэслэн МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 05-р сарын 05-ны өдрийн А/42 тоот тушаалаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн үнэт цаасыг III дугаар ангиллаас ахиулан II дугаар ангилалд бүртгэсэн.

2023 оны 01-р сарын 23-ны өдөр МХБ-ийн Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журмын дагуу ТОП-20 индексийн багцыг шинэчилсэн. 2022 оны үзүүлэлтээр ТОП-20 индексийн багцыг шинэчлэхэд өмнөх багцад багтаж байсан 15 компани хэвээр үлдэж, харин шинээр 5 компани нэмэгдэн шинэчилсэн багцыг бүрдүүлж байна. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь МХБ-ийн ТОП 20 индексийн сагсанд шинээр нэмэгдсэн.

2022 оны 12-р сарын 31-ны байдлаар Компанийн зах зээлийн үнэлгээ 139.9 тэрбум төгрөг байсан ба МХБ-ийн зах зээлийн үнэлгээгээр 12-т эрэмбэлэгдэж, нийт зах зээлийн 2.2 хувийг бүрдүүлж байна. MSE:CUMN хувьцаа нь 2022 онд МХБ-ийн хувьцааны арилжааны үнийн дүнгийн эрэмбээр 4-т, арилжаалагдсан тоо ширхгийн эрэмбээр 2-т тус тус жагссан. 2022 оны байдлаар нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 4.8 хувийг эзэлж байна.



МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Компани нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хангах үүднээс Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах, <https://hural.cumongol.mn> веб хаягаар хуралд бүртгүүлэх, урьдчилан санал өгөх боломжоор хангасан. Мөн тус хуралд ТУЗ-ийн бүх гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон Компанийн хөндлөнгийн аудитор байгууллагын төлөөлөгчид оролцож дээрх асуудлуудтай холбогдох хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт, тодруулга өгсөн.

2021 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;

- 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар, саналын хуудас, материал;
- 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрүүд болон тэмдэглэл;
- 2022 оны 1-р улирал болон хагас жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан;
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан; болон
- Бусад тухай бүр мэдээлэх мэдээлэл.

Мөн Компанийн гүйцэтгэх удирдлага нь улирал бүр МХБ-ийн байранд үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнгээ Монголын брокер, дилерийн компаниудын төлөөлөлд биечлэн танилцуулж, холбогдох асуултад хариулж, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр ханган ажилласан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлж, хяналт тавин ажилладаг. ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд эдгээр гишүүдийн 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүд юм.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Р.Ганболд нь 2022 оны 1-р сарын 28-ны өдрөөр үүрэгт ажлаас чөлөөлөгдсөнөөр түүний оронд Н.Энхболдыг ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүнээр түр томилсон бөгөөд 2022 оны 4-р сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь үүрэгт ажлаас чөлөөлж дахин сонгосноор Н.Энхболд нь ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон. Н.Энхболд нь Компанийн эрх бүхий албан тушаалтан биш юм. Түүнчлэн ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Мэргэн нас барсан тул 2022 оны 6-р сарын 10-ны өдөр В.Ганзоригийг ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр түр томилсон бөгөөд 2023 оны 4-р сарын 29-ний өдөр зохион байгуулагдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар түүнийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгох асуудлыг хэлэлцүүлнэ. В.Ганзориг нь нь Компанийн эрх бүхий албан тушаалтан биш юм.

ТУЗ нь холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангах зорилгоор 2022 оны 6-р сарын 13-ны өдөр Н.Энхболдыг Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны даргаар томилсон. ТУЗ нь шинээр сонгогдсон ТУЗ-ийн хараат бус гишүүдэд Компанийн үйл ажиллагаа, бизнес, дүрэм журмыг танилцуулан, чиглүүлэх сургалтыг хийсэн бөгөөд Компани нь ТУЗ болон түүний хороодын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг тухай бүр СЗХ болон МХБ-д мэдэгдэж, мэдээллээр хангаж ажилласан.

ТУЗ-ЫН ГИШҮҮД



А.ГАНХУАГ
ТУЗ-ийн дарга

А.Ганхуяг нь Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, Премиум Групп ХХК болон Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн дарга, Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгч бөгөөд сүүлийн 20 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (НКЕХ: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгээр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургуулийг санхүү, эдийн засгийн бакалаврын зэрэгтэй төгссөн



А.ГАНБОЛД
ТУЗ-ийн гишүүн

А.Ганболд нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Премиум Групп ХХК-ийн охин, хараат компаниудын үйл ажиллагааг удирдан, стратегийн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бүтцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Түүний барилгын салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан юм. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль ("ШУТИС")-ийг цахилгаан тээвэр, системийн инженер мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй.



Г.БАТ-ЭРДЭНЭ
ТУЗ-ийн гишүүн

Г.Бат-Эрдэнэ нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Групп ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч бөгөөд тус группийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хариуцан ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 18 жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



О.БАТМӨНХ
ТУЗ-ийн гишүүн

О.Батмөнх нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Групп ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Дэд ерөнхийлөгч, Премиум Конкрит ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд тус группийн уул уурхай, барилга, бетон зуурмагийн бизнесийг хариуцан ажилладаг. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал (NUBIA), Шангри-Ла зочид буудал цогцолбор төсөл, Салхит (50 МВт), Сайншанд (55 МВт), Цогтцэций (50 МВт) зэрэг салхин цахилгаан станцын төслүүд, Оюу толгой Бетон зуурмагийн 4 дүгээр үйлдвэрийн цогцолбор болон бутлуурын үйлдвэрүүдийн зураг төсөл, барилга, үйл ажиллагааг хариуцах зэргээр томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн, бизнесийн удирдлагын чиглэлээр 15 жил ажилласан туршлагатай. Тэрээр АНУ-ын Үндэсний Их Сургуулийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр төгссөн.



Б.БАТ-ЭРДЭНЭ
ТУЗ-ийн гишүүн

Б.Бат-Эрдэнэ нь Сэнтрал Экпресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Хорайзон Партнерс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, худалдааны чиглэлээр 12 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Польш, АНУ, Швейцар улсад сурч, Монголын анхны гадаадын (Японы) хөрөнгө оруулалтын банканд зах зээлийн шинжээчээр, Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалттай Монголын анхны хаалттай хөрөнгө оруулалтын санд (50 сая ам. долларын) зах зээл, бизнесийн шинжээчээр, Польш-Монголын хамтарсан худалдааны компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан ба Азийн Хөгжлийн Банкны Монгол улсад “Private Equity” болон “Venture Capital” хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компаниар ажилласан хөрөнгө оруулалт, стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээний компанийн үүсгэн байгуулагч юм. Б.Бат-Эрдэнэ нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.



Н.ЭНХБОЛД
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Н.Энхболд нь Сэнтрал Экпресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд 2016 оноос Ньюком Группийн Гүйцэтгэх захирлаар, 2017 оноос 2022 оныг хүртэл ТУЗ-ийн даргаар ажиллаж тус группийн өсөлтийг тасралтгүй хангах, үнэ цэнийг бий болгохын тулд гүйцэтгэх удирдлагын багтай хамтран ажилласан. Тэрээр хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлага, санхүү, төсөл боловсруулалт, корпорацийн стратеги, бизнес хөгжил, үйл ажиллагаа зэрэг Ньюкомын бүхий л салбар нэгжид идэвхтэй үүрэг гүйцэтгэн ажилласан бөгөөд тус группийн хөрөнгө оруулалттай компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар мөн ажиллаж байсан. Тэрээр өмнө нь М-Си-Эс Группийн стратеги, бизнес хөгжил хариуцсан дэд захирал, группийн бусад компаниудад гүйцэтгэх удирдлагаар 17 жил ажиллахдаа мэдээллийн технологи, харилцаа холбоо, санхүү, үл хөдлөх хөрөнгө зэрэг олон салбарт ажилласан туршлагатай бөгөөд 2013 онд төрийн дээд шагнал Алтан гадас одонгоор шагнуулсан. Н.Энхболд нь Нидерландын Маастрихтын Удирдлагын Сургуулийг корпорацийн стратеги, бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй, МУИС-ийг электроникийн инженер, бакалаврын зэрэгтэй төгссөн.



В. ГАНЗОРИГ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

В.Ганзориг нь стратеги ба коммуникацийн чиглэлээр мэргэшсэн Бат Солюшн Партнерс ХХК-ийн Удирдах зөвлөлийн дарга, “CEO” клубийн ерөнхийлөгч, Монголын Дауны Холбоо, Менторшигийн залуу мэргэжилтнүүдийн хөтөлбөрийн тэргүүн, Монголын Тусгай Олимпын Хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, “Global Teacher Prize”-ийн академийн гишүүн, Синдикат ярилцлага нэвтрүүлгийн модератор, тэргүүлэх мэдээллийн сайтуудын нийтлэлчээр ажилладаг.

Тэрээр Худалдаа Хөгжлийн Банк, ХасБанк, МОСДАК, Шунхлай Группийн удирдлагын багт ажиллаж байсан туршлагатай бөгөөд Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2014 оны дэлхийн залуу манлайлагчаар шалгарсан.

В.Ганзориг нь Японы Олон Улсын Их Сургуулийг цахим бизнесийн удирдлагын магистр, Австралийн Нотре Даме Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд АНУ (Virginia, Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS, Cape Town), Сингапур (NUS) улсуудад удирдлага, манлайлал, бодлогын инновац, гео улс төр, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан Монгол Улсын мэргэшсэн зөвлөх юм.



ГАРИ СТИВЕН БИОНДО

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Улаанбаатар дахь Олон Улсын Дунд Сургуулийн ТУЗ-ийн дарга, Жуулчин Уорлд Турс ХХК-ийн ахлах зөвлөх, Эдельвайс Арт зочид буудлын гүйцэтгэх захирал бөгөөд Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол)-ын ТУЗ-ийн дэд даргаар ажиллаж байсан. Тэрээр 30 гаруй жил зочид буудлын менежментийн салбарт, тэр дундаа ажилчдын сургалтын хөтөлбөр, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, чанар, дотоод хяналтын удирдлага, галын аюул, осол үүсэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан туршлагатай. Гари Биондо нь Азийн

өөр өөр соёл иргэншилтэй олон улс орнуудад өндөр зэрэглэлийн Шангри-Ла олон улсын зочид буудал, резортод 28 жил ерөнхий менежер, гүйцэтгэх удирдлагаар ажилласан бөгөөд АНУ-ын Колорадо мужийн Колорадо Коллежийг сонгодог уран зохиол, гүн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

ТУЗ-ийн гишүүдийн хувьцаа эзэмшлийн хувь хэмжээ (2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар)

ТУЗ-ийн гишүүний нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо		Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	
	Шууд	Шууд бус	Шууд	Шууд бус
А.Ганхуяг	254,492,419	3,009,965	31.12%	0.37%
А.Ганболд	172,327,784	2,291,714	21.07%	0.28%
Г.Бат-Эрдэнэ	19,948,820	252,423	2.44%	0.03%
О.Батмөнх	20,001,751	252,423	2.45%	0.03%
Г.Чинзориг	44,150	-	0.01%	-
Б.Бат-Эрдэнэ	80,000	-	0.01%	-
Н.Энхболд	961,538	-	0.12%	-
В.Ганзориг	2,709	-	0.00%	-
Гари Биондо	-	-	-	-

ТУЗ-ИЙН ХОРООД

Компанийн ТУЗ-ийн дэргэд Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо (“БОНЗ хороо”), Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо болон Аудитын хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд холбогдох журамд заасан эрх, үүргийн хүрээнд дүрэм, журам, санал, зөвлөмж боловсруулж, удирдамж, зааварчилгаа өгч ажилладаг.

БОНЗ хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүд болох О.Батмөнх, Б.Бат-Эрдэнэ болон ТУЗ-ийн хараат бус гишүүн Гари Стивен Биондо нараас бүрдсэн 3 гишүүнтэй бөгөөд Гари Стивен Биондо нь тус хорооны дарга юм. БОНЗ хороо нь Компанийн байгаль орчин, нийгэм, засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, зөвлөмж өгч ажилладаг.

БОНЗ ХОРОО

Тайлант хугацаанд тус хороо нь Компанийн Ёс зүйн дүрэм, Мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журам, Дотоод мэдээлэл түүнийг эзэмшигчдийн үйл ажиллагааны журам, Эрх мэдлийн хуваарилалтын гарын авлага, Комплайнсын хяналтын заавар, Компанийн засаглалын кодескыг хэрэгжүүлэх хөтөлбөр, Дотоод хяналтын зааврын төслүүдийг боловсруулан ТУЗ-д танилцуулж, улмаар ТУЗ тэдгээр дүрэм журмуудыг хэлэлцэн баталсан.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Нэр дэвшүүлэх хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Энхболд, хорооны гишүүдээр ТУЗ-ийн дарга А.Ганхуяг болон В.Ганзориг нар ажиллаж байна. Тус хороо нь ТУЗ, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх, тэдгээрийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, залгамж халааг төлөвлөх, тэдгээртэй холбоотой зөвлөмжийг ТУЗ-д гарган ажилладаг.

Тайлант хугацаанд Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн Залгамж халааны бодлогын төслийг боловсруулж ТУЗ-өөр батлуулсан бөгөөд Компанийн хүний нөөцийн төлөвлөлт, шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүнд болон Гүйцэтгэх удирдлагаас Компанийн эрх бүхий албан тушаалтнаар томилохыг санал болгосон нэр дэвшигчдийн мэргэжлийн ур чадвар, боловсрол зэргийг тухай бүр хянан хэлэлцэж, нийт 8-н зөвлөмжийг боловсруулан ТУЗ-д хүргүүлсэн.

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Цалин урамшууллын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүд Н.Энхболд, гишүүдээр ТУЗ-ийн ердийн гишүүн А.Ганболд болон Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нар ажиллаж байна. Тус хороо нь Компанийн цалин урамшууллын бодлого, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын хэмжээний дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал, дүгнэлтийг ТУЗ-д танилцуулах үүрэгтэй. Тайлант хугацаанд Цалин урамшууллын хороо нь Компанийн Цалин урамшууллын бодлогын төслийг боловсруулж ТУЗ-өөр батлуулсан бөгөөд ТУЗ-ийн гишүүн болон эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлуудыг тухай бүр хэлэлцэж, нийт 10 зөвлөмжийг ТУЗ-д хүргүүлэн ажилласан.


АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг, хорооны гишүүдээр ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Бат-Эрдэнэ болон хараат бус гишүүн Гари Стивен Биондо нар ажиллаж байна. Тус хороо нь Компанийн санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийг үнэлэх, хөндлөнгийн аудитортай хамтран ажиллах, ТУЗ-д санал, зөвлөмж гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд Аудитын хороо нь нийт 3 удаа хуралдаж Компанийн 2021 оны жилийн, хагас жилийн болон улирлын нэгтгэсэн санхүүгийн тайлан, хараат бус аудиторын тайлан, Компанийн хөндлөнгийн аудитор, хараат бус үнэлгээний байгууллагыг сонгох, их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянан хэлэлцэж, нийт 10 зөвлөмжийг ТУЗ-д танилцуулж батлуулсан байна.

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн ТУЗ нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд ТУЗ нь 9 удаа хуралдсан бөгөөд эдгээр хуралд ТУЗ-ийн гишүүд бүгд оролцож, хурлын ирц 100 хувьтай байсан. Мөн Компанийн урт болон богино хугацааны стратеги төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, экспорт, импортын үйл ажиллагаа эрхлэх охин компанийг байгуулах, охин компанийн оноосон нэр, үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэх, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох, ногдол ашиг хуваарилах эсэх зэрэг Компанийн үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн асуудлуудыг хэлэлцэн нийт 33-н шийдвэр тогтоол гарган ажилласан. Түүнчлэн ТУЗ нь 2022 онд ТУЗ-ийн хороодын зөвлөмж гарган ТУЗ-р батлуулсан дүрэм журмуудаас гадна Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам, Ногдол ашгийн журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Байгаль орчин, нийгэм, засаглалын хорооны үйл ажиллагааны журам, Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам, Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам, Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг хэлэлцэн баталж, ТУЗ-ийн дарга, гишүүд болон ТУЗ-ийн хороодын эрх, үүргийг тодорхойлж, тэдгээрийг чиг үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоог хангаж ажилласан.




ТУЗ болон ТУЗ-ийн хороодын дарга, гишүүдийн хуралд оролцсон ирц

ТУЗ-ийн гишүүний нэр	ТУЗ		БОНЗ хороо				Нэр дэвшүүлэх хороо				Цалин урамшууллын хороо				Аудитын хороо		Хувицаа	
	Хурлын тоо/ирц	Тогтоолын тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Хурлын тоо/ирц
А.Ганхуяг	9/9	37/37	-	-	0/0	8/8	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1/1
А.Ганболд	9/9	37/37	-	-	-	-	0/0	10/10	-	-	-	-	-	-	-	-	-	1/1
Г.Бат-Эрдэнэ	9/9	37/37	-	-	-	-	-	-	-	3/3	10/10	-	-	-	-	-	-	1/1
О.Батмөнх	9/9	37/37	0/0	4/4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1/1
Г.Чинзориг	9/9	37/37	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1/1
Б.Бат-Эрдэнэ	9/9	37/37	0/0	4/4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1/1
Н.Энхболд	9/9	37/37	-	-	0/0	8/8	10/10	-	-	-	-	-	-	-	-	-	-	1/1
В.Ганзориг	9/9	37/37	-	-	0/0	8/8	-	-	-	1/1-	5/5	-	-	-	-	-	-	1/1
Гари Биондо	9/9	37/37	0/0	4/4	-	-	-	-	-	3/3	10/10	-	-	-	-	-	-	1/1

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

ТУЗ-ийн дарга, гишүүд болон нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх удирдлага нар нь Компанийн эрх бүхий албан тушаалтнууд юм. 2022 оны 09-р сард ТУЗ нь Нэрдэвшүүлэх хорооны саналыг үндэслэн Санхүүгийн газрын захирал, Захиргаа, хүний нөөцийн газрын захирал, Борлуулалт, үйлчилгээний газрын захирал, Дэлгүүр хөгжүүлэлтийн газрын захирал, Маркетингийн газрын захирал, Мэдээллийн технологийн газрын захирал, Ханган нийлүүлэлтийн газрын захирал, Мерчиндайзингийн газрын захирал болон Эрсдэлийг бууруулах газрын захирал нарыг Компанийн эрх бүхий албан тушаалтнаар мөн тооцохоор шийдвэрлэсэн бөгөөд ТУЗ болон эрх бүхий албан тушаалтнуудын эрх мэдлийн хэмжээг тодорхойлсон баримт бичгийг 07-р сард баталсан.



УДИРДЛАГЫН БАГ



Г.ЧИНЗОРИГ
Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-н Гүйцэтгэх захирал



Д. ЖҮГДЭРНАМЖИЛ
Сэнтрал Фүүдс ХХК-н Гүйцэтгэх захирал



Г.САРАНГЭРЭЛ
Захиргаа, хүний нөөцийн газрын захирал



Б.БИЛГҮҮНЖАВ
Мерчандайзингийн газрын захирал



Б.ЦЭВЭЛМАА
Ханган нийлүүлэлтийн газрын захирал



Д.БУДХАНД
Санхүүгийн газрын захирал

УДИРДЛАГЫН БАГ



Г.ЦЭРЭНЖАГЗАН
Мэдээллийн технологи, хөгжүүлэлтийн дарга



Г.ГЭРЭЛТ-ОД
Дэлгүүр хөгжүүлэлтийн газрын захирал



Ц.НОМИНЗОЛ
Төслийн лийд




Д.НЯМСҮРЭН
Эрсдэлийг бууруулах газрын захирал



Г.БАТБААТАР
Маркетингийн газрын захирал

2022 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

БҮЛЭГ 4



ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн дарга, гишүүд нь тус бүр татварын өмнөх дүнгээр сар бүр 3,000,000 төгрөгийн цалин авдаг бөгөөд аливаа бусад төрлийн урамшуулал авдаггүй. Түүнчлэн ТУЗ-ийн дарга, гишүүд нь хороодод ажилласны нэмэгдэл цалин урамшуулал авдаггүй. ТУЗ-ийн дарга, гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтнуудад 2022 онд олгосон сарын цалин урамшууллын хэмжээг үнийн дүнгээр багцлан доорх хүснэгтэд харуулав.

Сарын үндсэн цалингийн хэмжээ (татварын өмнөх, төгрөг)	Эрх бүхий албан тушаалтны тоо
10,000,001 болон түүнээс дээш	2
5,000,001–10,000,000	6
≤5,000,000	4

Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан Компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа даган мөрдөж, хэрэгжүүлэн ажилласан бөгөөд нэгдсэн үнэлгээний хүрээнд дараах үзүүлэлтэй байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ

Нэгдсэн дүнгээс харахад Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ нь 94.8 хувь буюу хэвийн засаглалтай гэсэн үрдүнтэй гарсан байна. Цаашид Компани нь өөрийн үнэлгээг тогтмол сайжруулах, шаардлагатай баримт бичгүүдийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн шинэчлэхэд анхаарч ажиллах болно.

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай МХБ болон компанийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

№	Шууд	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8	80%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%
	Нэгдсэн дүн	72	68	94.8%

ХАВСРАЛТ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК

Нэгтгэсэн болон Тусдаа санхүүгийн тайлангууд

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

(Хараат бус аудиторын тайлангийн хамт)

Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Группийн болон Компанийн удирдлага нь нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани") ба түүний охин компаниуд (хамтад нь "Групп" гэх)-ийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Группийн болон Компанийн удирдлага нь энэхүү нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан нь Группийн болон Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Группийн болон Компанийн удирдлага нь нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангууд нь Тодруулга 2-6-д дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Группийн болон Компанийн удирдлага нь Группийн болон Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Группийн болон Компанийн удирдлага нь нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлэмж хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Группийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Группийн болон Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Д.Бүдханд
Санхүүгийн газрын захирал,
Бизнес контроллер

Монгол Улс,
Улаанбаатар хот
2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скей Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бус Аудиторын Тайлан

Сэнтрал Экспресс Си Ви Эс Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Бид Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (цаашид “Компани” гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь “Групп” гэх)-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан нь Групп болон Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС-ын Стандартууд (цаашид “СТОУС-ын Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Нэгтгэсэн болон Тусдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУС3-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Групп болон Компаниас хараат бус байж, НБЁЗОУС3-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Аудитын Гол Онцлох Зүйлс

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гараагүй болно.



Аудитын Гол Онцлох Зүйлс, Үргэлжлэл

Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлт

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн Тодруулга 26, мөн Тодруулга 3-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгуудыг харна уу.

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
<p>Аудитын Олон Улсын Стандартад борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой залилангийн эрсдэлийг томоохон эрсдэл гэж үздэг. Бид борлуулалтын орлого бодитоор үүссэн эсэхэд үг эрсдэлийг авч үзсэн ба тухайлан франчайз эрх хүлээн авагчтай холбоотой борлуулалтын орлогод үг эрсдэлийг авч үзсэн.</p> <p>Дээрх зүйлстэй холбоотойгоор бид франчайз эрх хүлээн авагчтай холбоотой борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн.</p>	<p>Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимууд:</p> <ul style="list-style-type: none"> - Бид удирдлагын зүгээс борлуулалт болон борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх үйл явцад хэрэгжүүлж буй хяналтууд, тэр дундаа франчайз эрх хүлээн авагчтай холбоотой борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн оршин байх болон үнэн зөв байх зэрэгтэй холбоотой хяналтуудыг шалгасан. - Бид Групп болон Компанийн франчайз эрх хүлээн авагчдаас олсон орлогыг шалгах үүднээс франчайз эрх хүлээн авагчид рүү тулган баталгаажуулах захидал явуулсан ба франчайз эрх хүлээн авагчидтай хийсэн гэрээг шалгах гэх мэт аудитын горимуудыг хэрэгжүүлсэн. - Бид Групп болон Компанийн жилийн туршид хүлээн зөвшөөрсөн борлуулалтын орлогыг Татварын Ерөнхий Газрын удирдаж, хэрэгжүүлдэг и-баримт систем рүү тулгасан. - Бид борлуулалтын орлогыг зохих санхүүгийн жилд борлуулалтын гэрээний нөхцөлийн дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгасан. - Бид удирдлага болон засаглах эрх бүхий этгээдүүдтэй тухайн тайлант жилд залилантай холбоотой орлого хүлээн зөвшөөрөлт болон хэвийн бус ажил гүйлгээ гарсан эсэх талаар ярилцлага хийсэн. - Бид борлуулалтын орлогыг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалган, холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг шалгасан.

Бусад Асуудал

Групп болон Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитыг өөр аудитор гүйцэтгэж, эдгээр тайлангуудад зөрчилгүй дүгнэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр гаргасан болно.



Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм. Хийж гүйцэтгэсэн ажлын хүрээнд бусад мэдээлэлд аливаа материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл бид энэ талаар тайлагнах үүрэгтэй. Бусад мэдээлэлтэй холбоотойгоор бидэнд тайлагнах зүйлс байгаагүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Нэгтгэсэн болон Тусдаа Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланг СТОУС-ын Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Групп болон Компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд тодруулж, Групп болон Компанийг татан бүүлгах юм үү үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Групп болон Компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Групп болон Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.



Нэгтгэсэн болон Тусдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Групп болон Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Групп болон Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Групп болон Компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор Групп дэх компаниудын санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагааны талаар аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Бид Группийн аудитыг гүйцэтгэх, хянах, удирдах үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтэнд хариуцлага хүлээнэ.



Нэгтгэсэн болон Тусдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бууруулсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Жу Сан Ён, аудитын компанийн Ерөнхий Захирал нь Г. Соёлмаа нар болно.



 Кэй Пи Эм Жи Аудит ХХК
 Монгол Улс, Улаанбаатар хот
 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Баталгаажуулсан:



Г. Соёлмаа
Ерөнхий Захирал

Баталсан:



Жу Сан Ён
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Групп болон Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК
Нэгтгэсэн болон Тусдаа санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тод-руулга	Нэгтгэсэн		Тусдаа	
		2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ					
Эргэлтийн бус хөрөнгө					
Үндсэн хөрөнгө	9	67,338,093	42,315,310	48,693,267	25,390,869
Ашиглах эрхтэй хөрөнгө	10	46,960,531	22,599,622	46,960,531	22,011,451
Охин компани дахь хөрөнгө оруулалт	11	-	-	7,725,396	7,724,396
Санхүүгийн түрээсийн авлага	13	3,455,416	4,092,438	3,455,416	4,092,438
Биет бус хөрөнгө	12	5,854,517	4,325,682	4,421,733	2,797,336
Бусад авлага	17	1,778,188	1,075,318	1,047,672	514,392
Урьдчилгаа	16	454,647	415,869	62,079	415,869
Хойшлогдсон татварын хөрөнгө	32	767,375	279,073	776,501	295,519
Нийт эргэлтийн бус хөрөнгө		126,608,767	75,103,312	113,142,595	63,242,270
Эргэлтийн хөрөнгө					
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт					
Бараа материал	15	31,838,373	14,072,542	28,617,577	13,300,216
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	19, 37	4,280,725	4,061,156	4,019,062	3,880,540
Урьдчилгаа	16	3,313,251	2,926,557	4,508,701	4,076,307
Дансны ба бусад авлага	17, 37	4,489,855	2,419,423	11,087,757	2,627,869
Зээлийн авлага	14, 37	-	2,016,877	-	2,016,877
Санхүүгийн түрээсийн авлага	13, 37	517,704	453,435	517,704	453,435
Нийт эргэлтийн хөрөнгө		44,439,908	40,811,341	48,750,801	41,216,595
НИЙТ ХӨРӨНГӨ		171,048,675	115,914,653	161,893,396	104,458,865
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ					
Хувьцаат капитал	20	81,776,864	81,776,864	81,776,864	81,776,864
Нэмж төлөгдсөн капитал	20	13,820,503	13,820,503	13,820,503	13,820,503
Эздийн өмчийн бусад хэсэг	35	318,731	318,731	-	-
Хуримтлагдсан алдагдал		(77,478,477)	(51,794,093)	(72,667,229)	(49,870,998)
НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		18,437,621	44,122,005	22,930,138	45,726,369
ӨР ТӨЛБӨР					
Урт хугацаат өр төлбөр					
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	10	49,410,996	26,918,102	49,410,996	26,776,866
Урт хугацаат зээл	21, 37	27,932,886	14,411,323	23,178,869	7,234,171
Бусад урт хугацаат өр төлбөр		953,091	89,444	898,319	-
Гэрээний өр төлбөр	25	264,848	325,463	264,848	325,463
Хойшлогдсон татварын өр төлбөр	32	287,593	326,068	-	-
Нийт урт хугацаат өр төлбөр		78,849,414	42,070,400	73,753,032	34,336,500
Богино хугацаат өр төлбөр					
Дансны ба бусад өглөг	24, 37	47,085,498	22,665,544	43,039,913	20,204,431
Түрээсийн өглөг	10, 37	7,905,463	3,807,028	7,905,463	3,011,657
Зээл	21, 37	17,280,869	2,077,020	12,902,042	83,877
Гэрээний өр төлбөр	25	602,570	648,151	583,259	628,853
Бусад татварын өглөг	23	867,480	474,627	759,789	417,300
Орлогын албан татварын өглөг		19,760	49,878	19,760	49,878
Нийт богино хугацаат өр төлбөр		73,761,640	29,722,248	65,210,226	24,395,996
НИЙТ ӨР ТӨЛБӨР		152,611,054	71,792,648	138,963,258	58,732,496
НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		171,048,675	115,914,653	161,893,396	104,458,865

Хуудас 6-55 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн болон Тусдаа санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК
Нэгтгэсэн болон Тусдаа Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянга төгрөгөөр	Тодруулга	Нэгтгэсэн		Тусдаа	
		2022	2021	2022	2021
Борлуулалтын орлого	26	261,018,893	94,038,017	261,722,623	94,271,990
Борлуулалтын өртөг	27	(265,272,083)	(101,050,925)	(265,213,381)	(100,177,420)
Нийт алдагдал		(4,253,190)	(7,012,908)	(3,490,758)	(5,905,430)
Ерөнхий, захиргааны болон борлуулалтын зардал	28	(12,187,007)	(7,709,307)	(11,301,899)	(7,537,847)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал		(94,177)	(145,538)	(94,177)	(144,538)
Бусад олз, цэвэр	29	324,869	608,317	329,438	696,280
Бусад орлого		37,786	250,167	815	224,392
Үйл ажиллагааны алдагдал		(16,171,719)	(14,009,269)	(14,556,581)	(12,667,143)
Санхүүгийн зардал	30	(11,147,568)	(5,700,494)	(9,832,114)	(5,093,505)
Санхүүгийн орлого	31	1,227,674	1,429,902	1,227,674	1,429,902
Орлогын албан татварын өмнөх алдагдал		(26,091,613)	(18,279,861)	(23,161,021)	(16,330,746)
Орлогын албан татварын зардал	32	407,229	11,062	364,790	(14,958)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АЛДАГДАЛ		(25,684,384)	(18,268,799)	(22,796,231)	(16,345,704)
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	-
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АЛДАГДАЛ		(25,684,384)	(18,268,799)	(22,796,231)	(16,345,704)
Группийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах нэгж энгийн хувьцаанд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны суурь болон хорогдуулсан ашиг (алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)	33	(31)	(38)	(28)	(34)

Хуудас 6-55 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн болон Тусдаа санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК
Нэгтгэсэн болон Тусдаа Өмчийн өөрчлөлтийн тайлан

<i>Мянган төгрөгөөр</i>	Тод-руулга	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Бусад өмч	Хуримтлагдсан алдагдал	Нийт эзэмшигчдийн өмч
Нэгтгэсэн						
2021 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл	20	17,145,256	-	-	(33,525,294)	(16,380,038)
Тайлант жилийн алдагдал		-	-	-	(18,268,799)	(18,268,799)
Бизнесийн нэгдэл (Нэгдмэл хяналт бүхий ажил гүйлгээ)	35	-	-	318,731	-	318,731
Гаргасан хувьцаа		64,631,608	13,820,503	-	-	78,452,111
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	20	81,776,864	13,820,503	318,731	(51,794,093)	44,122,005
Тайлант жилийн алдагдал		-	-	-	(25,684,384)	(25,684,384)
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	20	81,776,864	13,820,503	318,731	(77,478,477)	18,437,621

<i>Мянган төгрөгөөр</i>	Тод-руулга	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан алдагдал	Нийт эзэмшигчдийн өмч
Тусдаа					
2021 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл	20	17,145,256	-	(33,525,294)	(16,380,038)
Тайлант жилийн алдагдал		-	-	(16,345,704)	(16,345,704)
Гаргасан хувьцаа		64,631,608	13,820,503	-	78,452,111
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	20	81,776,864	13,820,503	(49,870,998)	45,726,369
Тайлант жилийн алдагдал		-	-	(22,796,231)	(22,796,231)
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	20	81,776,864	13,820,503	(72,667,229)	22,930,138

Хуудас 6-55 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн болон Тусдаа санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Сэнтрап Экспресс Си Ви Эс ХК
Нэгтгэсэн болон Тусдаа Мөнгөн гүйлгээний тайлан

<i>Мянган төгрөгөөр</i>	Тодруулга	Нэгтгэсэн		Тусдаа	
		2022	2021	2022	2021
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ					
	Татварын өмнөх алдагдал	(26,091,613)	(18,279,861)	(23,161,021)	(16,330,746)
	<i>Тохируулууд:</i>				
	Элэгдэл	9	9,341,514	5,285,638	7,781,358
	Үндсэн хөрөнгө борлуулсны (олз)/гарз	9	(74,903)	30,992	21,235
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	9	-	29,913	-
	Биет бус хөрөнгийн хорогдуулга	12	895,056	611,698	761,445
	Бараа материал данснаас хассаны гарз	15	12,888,705	3,571,046	12,445,024
	Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	17	94,177	145,538	94,177
	Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	10	7,683,104	3,624,672	7,372,732
	Гадаад валютын ханшийн зөрүү	29	(223,570)	120,102	(90,177)
	Хөрөнгө оруулалт борлуулсны гарз		11,452	-	11,452
	Санхүүгийн орлого	31	(1,227,674)	(1,429,902)	(1,227,674)
	Санхүүгийн зардал	30	10,934,608	5,689,151	9,619,154
	Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	10	(390,497)	(706,646)	(116,196)
	Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		13,840,359	(1,307,659)	13,511,509
	<i>Ажлын капиталын өөрчлөлтийн дүн:</i>				
	Дансны ба бусад авлага	17	(2,867,479)	(477,454)	(9,087,345)
	Бараа материал	15	(33,409,437)	(10,525,886)	(30,517,286)
	Дансны ба бусад өглөг	24	22,694,407	14,989,550	21,011,214
	Урьдчилгаа	16	(386,694)	(1,726,873)	(432,394)
	Бусад татварын өглөг	23	392,853	(49,719)	342,489
	Гэрээний өр төлбөр	25	(106,196)	516,450	(106,209)
	Ажлын капиталын өөрчлөлтийн дараах үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		157,813	1,418,409	(5,278,022)
	Зээлийн хүүгийн төлөлт	22	(2,545,882)	(1,770,685)	(1,197,832)
	Орлогын албан татварын төлөлт		(149,666)	(19,790)	(146,310)
	Түрээсийн өглөгийн хүү төлөлт	22	(7,363,313)	(3,987,607)	(7,358,458)
	Хүлээн авсан хүүгийн орлого		1,227,674	573,856	1,227,674
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(8,673,374)	(3,785,817)	(12,752,948)
					(3,143,506)

Хуудас 6-55 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн болон Тусдаа санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК
Нэгтгэсэн болон Тусдаа Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Нэгтгэсэн		Тусдаа	
		2022	2021	2022	2021
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	9	(30,125,660)	(13,739,877)	(26,428,016)	(12,561,674)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	9	291,915	25,863	171,242	25,863
Худалдаж авсан биет бус хөрөнгө	12	(1,362,604)	(542,004)	(1,312,604)	(527,052)
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	12	11,951	-	-	-
Санхүүгийн түрээсийн авлагын төлөлт	10	572,753	338,880	572,753	338,880
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	35	-	242,776	(1,000)	-
Зээлийн авлагын өөрчлөлт	14	2,016,877	(2,000,000)	2,016,877	(2,000,000)
Худалдаж авсан өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт		-	(14,700,000)	-	(14,700,000)
Худалдсан өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт		14,849,899	-	14,849,899	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(13,744,869)	(30,374,362)	(10,130,849)	(29,423,983)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ					
Гаргасан хувьцаа		-	29,616,600	-	29,616,600
Авсан зээл	22	42,841,999	5,192,725	42,841,999	2,886,667
Зээлийн эргэн төлөлт	22	(15,142,000)	(570,000)	(15,142,000)	(416,667)
Түрээсийн өр төлбөрийн төлөлт	10, 22	(5,062,187)	(2,122,067)	(4,677,680)	(1,742,648)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		22,637,812	32,117,258	23,022,319	30,343,952
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)					
		219,569	(2,042,921)	138,522	(2,223,537)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
		4,061,156	6,104,077	3,880,540	6,104,077
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл					
		4,280,725	4,061,156	4,019,062	3,880,540

Хуудас 6-55 д хавсаргасан Тодруулгууд нь эдгээр Нэгтгэсэн болон Тусдаа санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

